

(ажил хайгчдад)

Зөв зохистой тэтгэмж авахын тулд сайтар уншиж танилцаарай.

(モンゴル語)

Хөдөлмөрийн даатгалын ажилгүйдлийн тэтгэмж авагчийн гарын авлага

Тэтгэмж авах эрх тогтоох огноо	рэйва он сар өдөр	магадлан тогтоох өдөр (гараг)
Тэтгэмж олгох дугаар	—	гараг
Овог нэр		

◎ Таны хөдөлмөрийн даатгалын тухай танилцуулга дараах өдөр болно.

Танилцуулга явагдах өдөр цаг	сар өдөр (гараг) цаг минут
------------------------------	-----------------------------

※ Хөдөлмөрийн даатгалын тухай танилцуулганд ирэхдээ ○ тэмдэглэсэн зүйлийг авч ирнэ үү.

1	Тэтгэмж авагчийн гарын авлага
2	Бичгийн хэрэгсэл
3	Төлбөр төлөгдөх санхүүгийн байгууллагыг тодорхойлох бичиг, эсвэл дансны хадгаламжийн дэвтэр (өөрийн нэрийн)
4	Зураг хувь (босоо 3 см× хөндлөн 2.5 см хэмжээтэй цээж зураг)
5	My number карт, хувийн дугаарын мэдэгдэх хуудас, хувийн дугаар бичигдсэн оршин суугчийн тодорхойлолт (※) -ын аль нэг
6	Жолооны үнэмлэх, улсаас хэвлэсэн биеийн байцаалт, мэргэшлийн гэрчилгээний (зурагтай) аль нэг (далайчин бол хөлгийн гишүүний дэвтэр)
7	Шаардлагатай мэдээлэл бичигдсэн оршин суугчийн тодохойлолт (оршин суугчийн тодорхойлолт, тамганы тодорхойлолт) Үндэсний эрүүл мэндийн даатгалын карт, эсвэл эрүүл мэндийн даатгалын карт
8	Бусад ()

(※) Тэтгэмж авах бүртгэлд хувийн дугаар шалгах бичиг баримт (My number карт г.м) шаардлагатай болно.

◎ Таны ажилгүйдлийг магадлан тогтоох эхний өдөр доорх хуваарийн дагуу болно.

Ажилгүйдэл магадлан тогтоох эхний өдөр	сар өдөр (гараг) цаг минут~ цаг минут
--	--

※ Магадлан тогтоох өдөр доорх зүйлийг заавал авч ирнэ үү.

Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ • Ажилгүйдэл тодорхойлох өргөдөл • бусад ()

Хөдөлмөрийн даатгалын тухай танилцуулга болох өдөр ирэх боломжгүй болвол заавал холбоо барина уу.

※ Хөдөлмөрийн даатгал авах бүртгэл хийвэл, бүртгэл хийсэн өдрөөс өмнөх хөдөлмөрийн даатгалд хамрагдаж байсан хугацаа нь үндсэн тэтгэмжийн олголт байх үгүйгээс үл хамааран, дараачийн хөдөлмөрийн даатгал олгох болзлын тооцоонд орохгүйг анхаарна уу.

※ Ойлгомжгүй зүйл байвал ажилтнаас лавлана уу.

※ Машины зогсоол хязгаартай тул, аль болох нийтийн тээвэр ашиглана уу.

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудсанд байршуулсан хөдөлмөрийн даатгалын тухай асуулт хариултыг харна уу.

【холбогдох URL】 <https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000139508.html>



Hello Work төв (Нийтийн хөдөлмөр эрхлэлт тогтвортой байдал хариуцсан газар)

Хөдөлмөрийн товчоо
Хөдөлмөр эрхлэлт тогтвортой байдал хариуцсан хэлтэс

LL020801保00



Hello Work төвөөр үйлчлүүлээрэй.

Hello Work төв нь та бүхнийг хүссэн ажилдаа аль болох түргэн орж тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд, ажил танилцуулахаас эхлээд, төрөл бүрийн үйлчилгээг үзүүлдэг.

Hello Work төв нь Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд харьяалагддаг улсын байгууллага тул, бүх үйлчилгээ үнэ төлбөргүй.

Доорх хэсэгт Hello Work төвийн гол үйлчилгээний талаар танилцуулах бөгөөд, та заавал ирж үйлчлүүлээрэй.

Hello Work төвөөр үйлчлүүлэхдээ **“Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ”** -г авч ирээрэй.

Ажлын талаар зөвлөх

Hello Work төвийн ажлын тухай зөвлөгөө хүлээн авах цонхонд, ажилд орохтой холбоотой төрөл бүрийн асуудлаар хандаж болно. Жишээлбэл “Санаанд таарсан ажлын байр олдохгүй байна”. “Сонирхож үзмээр ажил байна, яавал дээр вэ...” гэх мэт ямар ч асуудал байж болно.

Мөн ажлын байрны нөхцөл байдлын талаар танилцуулах, түргэн дахин ажилд ороход тус болох зөвлөгөө өгөх г.м.

Ажлын байрны тухай мэдээлэл өгөх

Hello Work төвд төрөл бүрийн байгууллагаас өдөр бүр шинэ ажлын байрны тухай мэдээлэл ирдэг.

Ажлын байрны мэдээллийг компьютер ашиглан хялбархан харж болно.

Мөн бусад Hello Work төвд ирсэн ажлын байрны тухай мэдээллийг ч танилцуулдаг тул, мэдээллийг өргөн хүрээнд авах боломжтой.

Таны хүссэн байгууллагад танилцуулна

Бүртгүүлмээр ажлын байр байвал, ажлын тухай зөвлөгөө хүлээн авах цонхонд хандана уу.

Тухайн ажлын талаар тайлбар, зөвлөгөөг өгч, байгууллагын хариуцсан хүнтэй ажлын ярилцлагын өдөр, цаг товлож, танилцуулах бичиг хийж өгнө.

Мөн ажлын байрны болзол нь таны нөхцөлд таарахгүй тохиолдолд, байгууллагатай ярилцаж тохируулах арга хэмжээ авна.


Ажил хайх дэмжлэг үзүүлэх

Hello Work төвөөс таны ажил хайх явцыг дэмжихийн тулд, өөрт тохирсон ажил хайх арга, ярилцлагад орох зөвлөгөө өгөх зэрэг төрөл бүрийн семинар зохион байгуулдаг. Семинарын хуваарь гэх мэт асуудлын талаар Hello Work төвүүдээс лавлаарай.

Бусад үйлчилгээ

Hello Work төв бүр төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг тул, тус тусын үйлчилгээний талаар Hello Work төвийн салбаруудаас лавлаарай.

Тэтгэмж авах бүртгэлийн дараалал



1 Хөдөлмөрийн даатгалын тэтгэмжийг ямар хүн авах вэ?

Хөдөлмөрийн даатгал нь, ажилгүй байх явцдаа ар гэртээ санаа зоволтгүй ажил хайхдаа төвлөрч, аль болохоор түргэн дахин ажилд орох явцыг дэмжих “**Ажил хайгчийн тэтгэмж**” олгодог.

Ажил хайгчийн тэтгэмж нь **ажилгүй болсон хүн заавал авдаг зүйл биш.**

Ажилгүйдлийн нөхцөл байдалд байгаа хүнд л олгогддог тэтгэмж юм.

2 Ажилгүйдлийн нөхцөл байдал гэж юу вэ?

Ажилгүйдлийн нөхцөл байдал гэдэг нь доорх болзлыг бүгдийг хангасан байхыг хэлнэ.

- ☐ Ажилд орох чин хүсэлтэй байх.
- ☐ Хэзээд ажилд ороход бэлэн (эрүүл мэнд, орчин зэргийн хувьд) байх.
- ☐ Ажил идэвхитэй хайж байгаа боловч ажил олдохгүй байх.

Доорх нөхцлийн аль нэгд хамаарах бол, зарчмын хувьд ажил хайгчийн тэтгэмж авах боломжгүй.

1. Өвчин, бэртэл гэмтэл зэргээс шалтгаалан шууд ажилд орох боломжгүй (Хөдөлмөрийн ослын даатгалын амралтын тэтгэмж [нөхөн төлбөр] болон эрүүл мэндийн даатгалын осол гэмтлийн тэтгэмжийн мөнгө гэх мэт төлбөр авч байгаа бол орно)
2. Жирэмслэлт, төрөлт, хүүхэд өсгөх зэрэг шалтгаанаар шууд ажилд орох боломжгүй.
3. Төрөл садны асаргаа зэргийн улмаас шууд ажилд орох боломжгүй
4. Тэтгэврийн нас зэрэг шалтгаанаар ажилгүй болж хэсэг хугацаанд амралт эдлэх
5. Гэр бүл болж гэрийн ажилд анхаарч ажил хийх хүсэлгүй
6. Гэрийн ажилд туслах болон хөдөө аж ахуй, худалдаа зэрэг гэр бүлийн бизнес эрхэлж, ажилд орох боломжгүй
7. Хувийн бизнес эрхлэх (бэлтгэж байгаа) ✖Орлого олсон эсэх хамаагүй.
8. Компанийн албан тушаалтанд томилогдсон (үйл ажиллагаа явуулж шагнал урамшуулал аваагүй бол Hello Work төвөөс лавлах)
9. Ажилд орсон (дагалдан, туршилтын хугацаа, дадлагын хугацаа орно, орлого олсон эсэх хамаагүй)
✖долоо хоногт ажлын цаг 20 цагаас бага бол ажилласан өдөр, орлогын хэмжээгээ мэдүүлэх шаардлагатай ба, бусад ажилгүйдлийн өдрүүдэд үндсэн тэтгэмж авч болох тохиолдол байдаг.
10. Сурах хүсэлтэй (өдөр нь сургуульд явдаг учир шууд ажилд орох боломжгүй)
11. Ажилд орох нь тогтсон (ажил олгох захиалга, санал авсан)
✖ 1.2.3.4.-ийн шалтгаанаар шууд ажилд орох боломжгүй бол, **тэтгэмж авах хугацааг сунгах** боломж байдаг.
(17-р хуудас)

Даатгал төлж байсан боловч ажил хайгчийн тэтгэмж авч чадахгүй байх тохиолдол байдаг уу?

Хөдөлмөрийн даатгал нь, хуримтлагдсан хуримтлал шиг даатгал төлж байвал заавал авна гэсэн тогтолцоо биш.

Хөдөлмөрийн даатгал нь, таны өөрийн даатгалаас гадна бусад хөдөлмөр эрхэлж буй хүмүүс, ажил олгогчийн даатгал болон татвараар төрөөс хэрэгжүүлдэг харилцан туслалцааны тогтолцоо юм.

Тиймээс хуулиар тогтоосон болзлыг хангаагүй бол тэтгэмж авч чадахгүй.

Ажил хиймээр байвч өвчин гэх мэт шалтгаанаар ажил хийж чадахгүй тохиолдолд яавал дээр вэ?

Ажил хайгчийн тэтгэмж авч болох нь, зарчмын хувьд ажилгүй болсон өдрийн дараагийн өдрөөс 1 жилийн хугацаанд байдаг. Уг хугацааг “Тэтгэмж авах хугацаа” гэнэ.

Ажлаас гарсны дараа, өвчин, жирэмслэлт зэрэг шалтгаанаар шууд ажил хийх боломжгүй байгаа хугацаанд, тэтгэмжийн хугацаа өнгөрчихвөл даатгалаа ашиглах боломжгүй болно.

Тиймээс тодорхой болзол хангасан тохиолдолд, уг тэтгэмжийн хугацааг тогтсон хугацаатайгаар сунгаж, дараа нь ажиллах боломжтой болмогц, хөдөлмөрийн даатгалын бүртгэл хийж болох тогтолцоо байдаг. (дэлгэрэнгүй мэдээллийг 17-р хуудаснаас).

Ажлаас гараад мэргэшлийн үнэмлэх авахын тулд өдөр нь сургуульд сурвал даатгал авахгүй юү?

Өдөр нь сургуульд сууснаар, өмнөх хуудсанд тайлбарласан “ажилгүйдлийн нөхцөл байдал”-д хамаарахгүй болвол, ажил хайгчийн тэтгэмж авч чадахгүй.

Мөн сургуулийн боловсролын тухай хуулийн 1-т заасан сургууль, уг хуулийн 124-т заасан мэргэжлийн сургууль эсвэл уг хуулийн 134-ийн 1-т заасан сургуулиудын оюутан эсвэл сурагч (цахим сургалт • оройн сургууль • цагийн сургууль орохгүй. Цаашид “өдрийн цагаар сурдаг оюутан” гэнэ) болон өдрийн цагаар сурдаг оюутантай адил нөхцөлтэй иргэний тухайд, зарчмын хувьд хөдөлмөрийн даатгалын хуулийн хүрээнд хөдөлмөр эрхлэгч болохгүй тул ажил хайгчийн тэтгэмж авах боломжгүй.

Ямар нөхцөл байдал нь “ажилд орсон” болох вэ?

Хөдөлмөрийн даатгалын тухай хуульд заасан “ажил эрхлэлт” гэдэг нь үндсэн ажилтан төдийгүй, цагийн ажил болон дадлагажигч зэргийг бүгдийг хэлнэ.

Мөн, компанийн албан тушаалтанд томилогдох, хувийн бизнесийн бэлтгэл болон хувийн бизнес эрхлэх, хөдөө аж ахуй, худалдаа арилжаа зэрэг гэр бүлийн бизнес эрхлэх, гэрээт ажил, төлөөлөн ажил гүйцэтгэх, гэрээсээ ажил хийх, сайн дурын үйл ажиллагаа ч “ажил эрхлэлт” болох тохиолдол байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг “12 Ажилгүйдэл тодорхойлох өргөдөл бичих арга”-с харна уу.

3 Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ

◎ Нүүрэн тал

雇用保険受給資格者証

(第1面)

1. 支 給 番 号	2. 氏 名		
3. 被 保 険 者 番 号	4. 性 別	5. 離 職 時 年 齢	6. 生 年 月 日
7. 求 職 番 号	8. 住 所 又 は 居 所		
9. 支払方法(記号(口座)番号 - 金融機関名 - 支店名)			
10. 資格取得年月日			
11. 離 職 年 月 日		12. 離 職 理 由	
13. 60歳到達時賃金日額		14. 離 職 時 賃 金 日 額	
15. 給 付 制 限		16. 求 職 申 込 年 月 日	
17. 認 定 日		18. 受 給 期 間 満 了 年 月 日	
19. 基 本 手 当 日 額		20. 所 定 給 付 日 数	
21. 通 算 被 保 険 者 期 間		22. 離 職 前 事 業 所 名	
23. 再 就 職 手 当 支 給 歴		24. 特 殊 表 示 (災 害 時 、 一 括 、 巡 相 、 市 町 村)	

◎ Арын нүүр

【 Ажлаас гарсан шалтгаан 11, 12, 21, 22, 23, 24, 25, 31, 32, 33 бол 】

行数	処 理 月 日	認 定 (支 給) 期 間	日 数	種 類	支 給 金 額	残 日 数	備 考
1	0530	20-012345-6		Коёо Тароо			Дараагийн магадлан тогтоох өдөр
2		Хүлээлтийн хугацаа дуусах	Хүлээлтийн хугацаа дуусах өдөр	020508			06 сарын 27 өдөр
3		020509-0529	21	Үндсэн тэтгэмж	¥○○○,○○○	69	
4							

「020509-0529」 「21」 гэдэг нь, ажилгүйдэл тодорхойлсон хугацааг (Рэйва 2-р (2020) он 5 сарын 9 өдөр～5 сарын 29 өдөр) гэж тогтоосон тэтгэмж олгох өдрийн тоо (21 өдөр).

Тэтгэмж авах үлдсэн өдрийн тоо.

【 Ажлаас гарсан шалтгаан 40, 50 бол 】 (тэтгэмжийн хязгаарлалттай тохиолдол)

行数	処 理 月 日	認 定 (支 給) 期 間	日 数	種 類	支 給 金 額	残 日 数	備 考
1	0530	20-012345-6		Коёо Тароо			Дараагийн магадлан тогтоох өдөр
2		Хүлээлтийн хугацаа дуусах	Хүлээлтийн хугацаа дуусах өдөр	020508			08 сарын 22 өдөр
3		Тэтгэмжийн хязгаарлалтын хугацаа	020509-020808	ажлаас гарсан шалтгаан 40			
4							

「020509-020808」 гэдэг нь, тэтгэмжийн хязгаарлалттай бол бичигдэх ба, уг хугацаанд (Рэйва 2-р (2020) он 5 сарын 9 өдөр～8 сарын 8 өдөр) үндсэн тэтгэмж олгогдохгүй.

Агуулгыг сайтар шалгана уу. Буруу бичигдсэн зүйл байвал ажилтанд хандаарай.

1	Тэтгэмж олгох дугаар	Тэтгэмж авахад зориулсан дугаар. Hello Work төв зэрэг (Hello Work төв эсвэл орон нутгийн тээврийн товчоо, далайн өөрийгөө хамгаалах хүчний оффис) байгууллагаас мэдээлэл лавлах, ажилгүйдэл тодорхойлох өргөдөлд бичих дугаар.
2	Овог нэр	Нэрийн дуудлага таарч байна уу? (Санхүүгийн байгууллагад бүртгэлтэй дуудлагатай зөрвөл шилжүүлэг хийх боломжгүй болох тул анхаарна уу.)
3	Даатгуулагчийн дугаар	Хөдөлмөрийн даатгалд, цаашид ажил хийх тохиолдолд ч уг дугаар ашиглагдана.
5	Ажлаас гарсан үеийн нас	Ажлаас гарсан үеийн бүтэн нас.
6	Төрсөн он сар өдөр	Эхний цифрийн “3” нь “шоова”, 4 нь “хэйсэй”-г илэрхийлнэ. “-”-н баруун хэсэг нь он сар өдөр байна.
9	Төлөх арга	Санхүүгийн байгууллагын нэр, салбарын нэр, дансны дугаар.
11	Ажлаас гарсан огноо	Таны ажлаас гарсан өдөр.
12	Ажлаас гарсан шалтгаан	Ажлаас гарсан шалтгааныг дугаараар илэрхийлнэ. 11、12 : Ажлаас халах (50-г оруулахгүй) 21 : Ажил олгогч хөдөлмөрийн гэрээ шинэчлэхээс татгалзах (Ижил ажил олгогч дээр 3-с дээш жил ажилласан) 22 : Ажил олгогч хөдөлмөрийн гэрээ шинэчлэхээс татгалзах (Ижил ажил олгогч дээр 3-с доош жил ажилласан, Гэрээ шинэчлэх нь тодорхой байх) 23 : Хугацаа дууссан (Ижил ажил олгогч дээр 3-с доош жил ажилласан, Гэрээ шинэчлэх боломжтой гэсэн тодорхой заалттай) 24 : Хугацаа дууссан (21~23-с бусад) 25 : Тэтгэврийн нас (Далайчин орохгүй) , Шилжин ажиллах 31、32 : Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажлаас гарах (ажил олгогчоос нөлөөлсөн г.м) 33 : Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажлаас гарах (31, 32-с бусад) 40、45 : Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хувийн шалтгаанаар ажлаас гарах 50、55 : Өөрийн буруугаас болж ноцтой шалтгаанаар ажлаас халагдах
14	Ажлаас гарах үеийн нэг өдөрт ноогдох цалин хөлсний хэмжээ	Зарчмын хувьд, ажлаас гарахын өмнөх 6 сарын хугацаанд төлөгдсөн цалин хөлсний нийлбэрийг 180-д хуваасан хэмжээ.
15	Тэтгэмжийн хязгаарлалт	Тэтгэмжийн хязгаарлалттай бол, уг хязгаарлалтын хугацаа.
16	Ажил хайх өргөдлийн огноо	Hello Work төвд ажлаас гарсан тухай хуудсаа өгч, ажил хайх өргөдөл гаргасан өдөр.
17	Ажилгүйдлийг магадлан тогтоох өдөр	Зүүн тал нь долоо хоногийн төрөл, баруун тал нь долоо хоногийн өдрийг заана. (11-р хуудас)
18	Тэтгэмж авах хугацаа дуусах өдөр	Үндсэн тэтгэмж авах хугацааны хамгийн сүүлийн өдөр.
19	Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ	Үндсэн тэтгэмжийн 1 өдөрт оногдох мөнгөний хэмжээ.
20	Тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо	Үндсэн тэтгэмж авах өдрийн дээд хэмжээ (8-р хуудас).
21	Даатгуулагч байсан нийт хугацаа	Даатгал төлж ажиллаж байсан нийт хугацааг хэлнэ (7-р хуудас).
23	Дахин ажилд орсон тэтгэмж олгосон түүх	Өмнө нь дахин ажилд орсон тэтгэмж авч байсан бол, хамгийн сүүлд тэтгэмж авсан өдөр.

☆ Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээг бусад зээлэх болон өгч болохгүй. Хэрэв гээгдүүлсэн тохиолдолд, даруй Hello Work төвд мэдэгдэх.

☆ Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээг компьютерт уншуулдаг тул, нугалж болох хэсгээс бусад хэсгийг нугалах, бохирдуулахгүй байх.

☆ Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээг тэтгэмж авч дууссаны дараа ч хадгалах.

4 Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ болон тэтгэмж авах өдрийн тоо гэж юу вэ?

Ажил хайгчийн тэтгэмжийн ажилгүйдлийн нөхцөл байдалд байгаа өдөрт олгох тэтгэмжийг “Үндсэн тэтгэмж” гэнэ.

- (1) **Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ** нь, зарчмын хувьд ажлаас гарахын өмнөх 6 сарын хугацаанд төлөгдсөн цалин хөлсний нийт хэмжээг **180-д** хуваасан мөнгөний (**өдөр тутмын цалин хөлс**) ойролцоогоор **80%~45%** байна (үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээнд дээд хэмжээ тогтоосон байдаг).
 ※ **Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ нь “сар бүрийн хөдөлмөрийн статистик”-н үр дүнд үндэслэн, жил бүр 8 сарын 1 өдөр шинэчлэгддэг.**
- (2) Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ нь насны бүлэг тус бүрээр дээд хэмжээ тогтоосон байдаг.
 (Үндсэн тэтгэмжийн төлбөр олгогдох өдөр нь 2020 оны 8 сарын 1 өдрөөс 2021 орны 7 сарын 31 өдөр хүртэлх тохиолдолд)

Өдөр тутмын цалин хөлс (w иен)	Тэтгэмжийн хувь	Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ (y иен)
--------------------------------	-----------------	--

● Ажлаас гарсан үеийн нас 30-с доош эсвэл 65 түүнээс дээш

2,574 иен, түүнээс дээш 5,030 иенээс доош	80%	2,059 иен~4,023 иен
5,030 иен, түүнээс дээш 12,390 иен хүртэл	80%~50%	4,024 иен~6,195 иен (* 1)
12,390 иенээс дээш 13,700 иен хүртэл	50%	6,195 иен~6,850 иен
13,700 иенээс дээш (дээд хэмжээ)	—	6,850 иен (дээд хэмжээ)

● Ажлаас гарсан үеийн нас 30 түүнээс дээш 45-с доош

2,574 иен, түүнээс дээш 5,030 иенээс доош	80%	2,059 иен~4,023 иен
5,030 иен, түүнээс дээш 12,390 иен хүртэл	80%~50%	4,024 иен~6,195 иен (* 1)
12,390 иенээс дээш 15,210 иен хүртэл	50%	6,195 иен~7,605 иен
15,210 иенээс дээш (дээд хэмжээ)	—	7,605 иен (дээд хэмжээ)

● Ажлаас гарсан үеийн нас 45 түүнээс дээш 60-с доош

2,574 иен, түүнээс дээш 5,030 иенээс доош	80%	2,059 иен~4,023 иен
5,030 иен, түүнээс дээш 12,390 иен хүртэл	80%~50%	4,024 иен~6,195 иен (* 1)
12,390 иенээс дээш 16,740 иен хүртэл	50%	6,195 иен~8,370 иен
16,740 иенээс дээш (дээд хэмжээ)	—	8,370 иен (дээд хэмжээ)

● Ажлаас гарсан үеийн нас 60 түүнээс дээш 65-с доош

2,574 иен, түүнээс дээш 5,030 иенээс доош	80%	2,059 иен~4,023 иен
5,030 иен, түүнээс дээш 11,140 иен хүртэл	80%~45%	4,024 иен~5,013 иен (* 2)
11,140 иенээс дээш 15,970 иен хүртэл	45%	5,013 иен~7,186 иен
15,970 иенээс дээш (дээд хэмжээ)	—	7,186 иен (дээд хэмжээ)

* 1 $y = 0.8w - 0.3 \{ (w - 5,030) / 7,360 \} w$

* 2 $y = 0.8w - 0.35 \{ (w - 5,030) / 6,110 \} w, y = 0.05w + 4,456$ аль бага хэмжээгээр

- (3) Үндсэн тэтгэмж авч болох өдрийн дээд хэмжээ нь **ажлаас гарсан өдрийн нас, даатгуулагчаар ажилласан (даатгал төлж ажилласан) хугацаа болон ажлаас гарсан шалтгаан** зэргээс хамаарч дараагийн хуудсанд үзүүлсэн хүснэгтийн дагуу тогтсон байдаг (үүнийг “Тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо” гэнэ).

Даатгуулагчаар ажилласан хугацаа

Ажлын байр солих зэргээс даатгуулах хугацаанд цоорхой гарсан бол, уг хугацаа 1 жилээс бага бол түүнээс өмнөх болон хойших даатгуулагч байсан хугацааг нийлүүлж тооцно. Гэхдээ өмнө нь үндсэн тэтгэмж (дахин ажилд орсон тэтгэмж зэрэг багтана.) эсвэл тусгай нэг удаагийн тэтгэмж авч байсан бол, уг тэтгэмж авсны дараах даатгуулагч байсан хугацааг л тооцно.

Түүнчлэн төр, хувийн хэвшлийн боловсон хүчний солилцооны тухай хуулийн 21-р зүйлийн 1-д заасан хөдөлмөр эрхлэлтийг үргэлжлүүлэн солилцох ажилтан байсан хугацаа болон хүүхэд өсгөх амралтын тэтгэмж авсан хугацааг (2019 он 10 сарын 1-с хойш) тэтгэмж тодорхойлох өдрийн тооцооноос хасна.

Тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо

- ① Гэрээний хугацаа дууссан, тэтгэвэрт гарсан, өөрийн хүслээр ажлаас гарсан иргэн
(② болон ③-с бусад бүх ажилгүй болсон иргэн)

Ажлаас гарсан үеийн нас / Даатгуулагч байсан хугацаа	10 жил хүртэл	10~20 жил хүртэл	20 жилээс дээш
Бүх нас	90 өдөр	120 өдөр	150 өдөр

- ② Дампуурал, ажлаас халагдах, тодорхой нөхцөлтэйгөөр ажил олгогч хөдөлмөрийн гэрээ сунгахаас татгалзаж ажилгүй болсон иргэн (③ орохгүй)

Ажлаас гарсан үеийн нас / Даатгуулагч байсан хугацаа	1 жил хүртэл	1~5 жил хүртэл	5~10 жил хүртэл	10~20 жил хүртэл	20 жилээс дээш
30-аас доош нас	90 өдөр	90 өдөр	120 өдөр	180 өдөр	—
30~35 нас хүртэл		120 өдөр	180 өдөр	210 өдөр	240 өдөр
35~45 нас хүртэл		150 өдөр		240 өдөр	270 өдөр
45~60 нас хүртэл		180 өдөр		270 өдөр	330 өдөр
60~65 нас хүртэл		150 өдөр	180 өдөр	210 өдөр	240 өдөр

※Тодорхой нөхцөлтэйгөөр ажил олгогч хөдөлмөрийн гэрээ сунгахаас татгалзаж ажилгүй болсон иргэнд ②-н хүснэгт үйлчлэх нь түр арга хэмжээ болно (2022 он 3 сарын 31 өдөр хүртэл ажлаас гарсан иргэн байх).

- ③ Хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар ажилд ороход хүндрэлтэй иргэн (тухайн хүнээс хүсэлт гаргах шаардлагатай)

Ажлаас гарсан үеийн нас / Даатгуулагч байсан хугацаа	1 жил хүртэл※	1 жилээс дээш
45-аас доош нас	150 өдөр	300 өдөр
45~65 нас хүртэл		360 өдөр

※ “1 жил хүртэл” багана нь ②-т заасан шалтгаан эсвэл аргагүй шалтгаанаар ажлаас гарсан иргэнд л үйлчилнэ.

5 Үндсэн тэтгэмж авах хугацаа гэдэг нь?

Үндсэн тэтгэмж авч болох хугацаа нь, зарчмын хувьд ажлаас гарсан өдрийн дараах өдрөөс 1 жилийн хугацаатай (тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо 330 өдөр бол 1 жил + 30 хоног, 360 хоног бол 1 жил + 60 хоног) байна. Энэ хугацааг “тэтгэмж авах хугацаа” гэнэ.


Уг хугацаан доторх ажилгүйдлийн нөхцөл байдалд байгаа өдөрт, тэтгэмж тодорхойлсон өдрийн тоогоор үндсэн тэтгэмж авах боломжтой.

Уг хугацаа өнгөрвөл тэтгэмж тодорхойлсон өдрийн тоогоор тэтгэмжээ авч дуусаагүй байсан ч хугацаа өнгөрснөөс хойших үндсэн тэтгэмжийг авах боломжгүй болно.

Жишээлбэл

Хувийн шалтгаанаар ажлаас гарсны дараа Hello Work төвд бүртгүүлэх нь оройтсон тохиолдол.


Тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо 150 өдөр байсан боловч • • •



Энэ тохиолдолд, 120 өдрийн тэтгэмж авснаар тэтгэмжийн хугацаа дуусгавар болох тул, 30 өдрийн тэтгэмж авах боломжгүй болно.

Гэхдээ өвчин, бэртэл гэмтэл, жирэмслэлт зэргээс шалтгаалан **үргэлжлүүлэн 30-с дээш хоног ажиллах чадамжгүй болсон тохиолдолд, тэтгэмжийн хугацааг сунгах** боломжтой (「16 Тэтгэмжийн хугацааны сунгалт гэдэг нь ?」-г харна уу)

Мөн, 8-р хуудасны ③-г хамаарах иргэний тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо 300 өдөр эсвэл 360 өдөр байгаад, 3 сарын тэтгэмжийн хязгаарлалттай бол, доорх тэтгэмжийн хугацааны тусгай заалт үйлчилнэ.



Энэ тохиолдолд, тэтгэмжийн эхний хугацаан дээр А-г нэмсэн хугацаа нь тэтгэмжийн хугацаа болно.

※ $A = 21 \text{ өдөр} + 3 \text{ сар (тэтгэмжийн хязгаарлалт)} + 300 \text{ өдөр (тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо)} - 1 \text{ жил}$

6 Эхлээд ажил хайх өргөдөл гаргах

Хөдөлмөрийн даатгалын бүртгэл нь, Hello Work төв зэрэгт (ажлаас гарсан далайчин нь үргэлжлүүлэн далайчнаар ажиллах хүсэлтэй бол орон нутгийн тээврийн товчоонд хандах) ажлаас гарсан тухай хуудсаа өгч, улмаар ажил хайх өргөдөл гаргаснаар эхэлнэ.

Уг бүртгэл хийсэн өдрийг “**тэтгэмж авах эрх тогтоох өдөр**” гэнэ.

“**Ажил хайх өргөдөл**” -д орохыг хүсэж буй ажлын төрөл, цалин зэргийг бөглөж өргөдлөө өгнө.


7 Тэтгэмж авах эрх тогтоосон өдрөөс хойших “Хүлээлтийн хугацаа”

Тэтгэмж авах эрх тогтоосон өдрөөс хойш ажилгүйдлийн байдалд байсан өдрийг тооцон нийт 7 хоног өнгөртөл үндсэн тэтгэмж авах боломжгүй байдаг. Уг хугацааг “**хүлээлтийн хугацаа**” гэнэ.

“Хүлээлтийн хугацаа”-ны сүүлчийн өдрийн дараах өдрөөс нь тэтгэмжид хамрагдах өдөр болох ба Hello Work төвөөс тогтоосон ажилгүйдлийг тодорхойлсон өдөрт оногдох үндсэн тэтгэмжийг олгоно.

8 Тэтгэмж олголт эхлэх (тэтгэмжийн хязгаарлалтгүй тохиолдолд)

Хүлээлтийн хугацаа өнгөрсний дараа (үүнийг “хүлээлтийн хугацаа дуусах” гэнэ), үргэлжлүүлэн ажилгүй байгаа бол үндсэн тэтгэмжид хамрагдана.



Ажилгүйдлийг магадлан тогтоох өдөр төвд ирж ажилгүйдлийн магадлагаа гаргуулбал “7 хоногийн хүлээлтийн хугацаа” болон “хүлээлтийн хугацаа дуусах өдрийн маргаашаас магадлан тогтоох өдрийн өмнөх өдөр хүртэл ажилгүйдлийн нөхцөл байдалд байгаа” нь батлагдаж үндсэн тэтгэмжийн олголт эхэлнэ.

9 Ажлаас гарсан шалтгаанаас хамаарч 3 сарын тэтгэмжийн хязгаарлалт байна.

Доор дурдсан нөхцөлийн аль нэгт хамаарах бол хүлээлтийн хугацаа дууссаны (үүнийг “хүлээлтийн хугацаа дуусах” гэнэ) дараагийн өдрөөс 3 сарын хугацаа өнгөрсний дараа үргэлжлүүлэн ажилгүйдлийн байдалд байгаа бол үндсэн тэтгэмжийн олголт эхэлнэ.

- ① Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хувийн шалтгаанаар ажлаас гарсан бол
- ② Өөрийн буруугаас болж ноцтой шалтгаанаар ажлаас халагдсан бол



Тэтгэмж авах нь, тэтгэмжийн хязгаарлалтын хугацаа дууссаны дараах магадлан тогтоох өдөр ажилгүйдлийн магадлагаа гаргуулсны дараа бөгөөд, **эхний магадлан тогтоох өдөр ажилгүйдлийн магадлагаа авахгүй бол хүлээлтийн хугацаа дууссанд тооцогдохгүй.**

Тэтгэмжийн хязгаарлалттай бол магадлан тогтоох өдөр Hello Work төв зэрэгт заавал ирж ажилгүйдлийн магадлагаа гаргуулах хэрэгтэй.

10 Тэтгэмж огт аваагүй байтал дараагийн ажил тодорхой болвол яах вэ?

Ажилд орох нь тодорхой болсон бол, ажилд орохын өмнөх өдөр Hello Work төв зэрэгт ажилд орох мэдэгдэл өгөх шаардлагатай (дэлгэрэнгүй мэдээллийг “20 Ажилд орох эсвэл бизнес эхлүүлэх нь тодорхой болсон үед яах вэ?”-г харна уу).

Үндсэн тэтгэмж болон дахин ажилд орсон зэргийн тэтгэмж авалгүй ажилд орсон бол, өнөөг хүртэл хөдөлмөрийн даатгалд хамрагдаж байсан хугацаа нэмэгдэж, хэрэв хойшид ажилгүй болсон бол хөдөлмөрийн даатгалын тэтгэмж тодорхойлох өдрийг тооцоолох үед, даатгал төлж ажиллаж байсан хугацаанд нэмэн оруулна.

Нэмэн тооцож болох хугацааны хүрээ болон болзолд хэд хэдэн нөхцөл байдаг тул дэлгэрэнгүй мэдээллийг Hello Work төвийн ажилтнаас лавлаарай.

11 Ажилгүйдлийн магадлалгаа гэж юу вэ?

Үндсэн тэтгэмж авахын тулд, зарчмын хувьд **4 долоо хоног (28 хоног)-т 1 удаа тогтсон өдөр (үүнийг ажилгүйдлийг магадлан тогтоох өдөр гэнэ)** өөрийн биеэр Hello Work төв зэрэгт ирж ажилгүйдлийн нөхцөл байдалд байсан (байгаа) гэдгээ **“ажилгүйдэл тодорхойлох өргөдөл”** гаргаж мэдэгдэх шаардлагатай.

“Ажилгүйдлийн нөхцөл байдал”-д байгаа эсэхийг бодитой, тодорхой баталгаажуулж байж тэтгэмж олгох нь чухал учир, **ажилгүйдлийг баталгаажуулах зорилгоор тодорхой хэмжээний хүрээнд ажил хайх үйл ажиллагаа явуулсан үр дүнд үндэслэн дүгнэх стандартыг тогтоосон. Ажилгүйдэл тодорхойлох өргөдөлд ажилгүйдлийн магадлалгаа гаргуулах гэж байгаа хугацаанд явуулсан ажил хайх үйл ажиллагааг үнэн зөв бичээрэй.** (ажилгүйдэл тодорхойлох өргөдлийн талаар “12 Ажилгүйдэл тодорхойлох өргөдөл бичих арга”-г , ажил хайх үйл ажиллагааны үр дүнгийн талаар “13 Ажил хайх үйл ажиллагааны үр дүн” -г харна уу).

Hello Work төвд уг өргөдлийн мэдүүлэгт үндэслэн, ажилгүйдлийн байдалд байсан өдрүүдийн ажилгүйдлийн магадлалаа тогтоож үндсэн тэтгэмж олгох бүртгэл хийгдэнэ.

“Ажилгүйдлийг магадлан тогтоох өдөр” -ийн тухай

Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээний магадлан тогтоох өдрийн хэсэгт, магадлан тогтоох өдрийн долоо хоногийн төрөл болон гараг бичигдсэн байна.

Хуанли ашиглаж магадлан тогтоох өдрийг олж мэдье.

曜日型	日	月	火	水	木	金	土
週型							
4	1	2	3	4	5	6	
1	7	8	9	10	11	12	13
9	2	14	15	16	17	18	20
3	21	22	23	24	25	26	27
4	28	29	30				
4				1	2	3	4
1	5	6	7	8	9	10	11
10	2	12	13	14	15	16	18
3	19	20	21	22	23	24	25
4	26	27	28	29	30	31	
4							1

“2-р төрөл-мягмар” гэж хэвлэгдсэн тохиолдолд

“2-р төрөл”-магадлан тогтоох өдрийн долоо хоногийн төрлийг заана (1-р төрлөөс 4-р төрөл хүртэл).

“мягмар”- долоо хоногийн өдрийг заана (даваа, мягмар, лхагва, пүрэв, баасан).

※2-р долоо хоногийн мягмар гараг гэсэн үг биш гэдгийг анхаараарай.

Зүүн гар талын хуанлийг харвал, долоо хоногийн төрөл 2 (хөндлөн) ба мягмар гарагийн (босоо) огтлолцсон 9 сарын 16 өдөр нь магадлан тогтоох өдөр болно.

Мөн дараагийн магадлан тогтоох өдөр нь 10 сарын 14 өдөр болно.

Анхаар

- ★ Магадлан тогтоох өдөр нь 1 сард 2 удаа байх тохиолдол байдаг.
- ★ Магадлан тогтоох өдөр нь амралт болон баярын өдөр таарвал Hello Work төвөөс магадлан тогтоох өдрийг өөрчилж төвийн зарлалын самбар сайт дээр байрлуулах зэргээр мэдэгдэнэ. Мэдээллийн самбарыг заавал шалгаарай.
- ★ Тэтгэмж авагчийн гэрчилгээнд дараагийн магадлан тогтоох өдөр хэвлэгдсэн байна.

12 Ажилгүйдэл тодорхойлох өргөдөл бичих арга

“Ажилгүйдэл тодорхойлох өргөдөл”-ийн тухай

Ажилгүйдэл тодорхойлох өргөдөл нь үндсэн тэтгэмж авахад чухал бичиг баримт тул үнэн зөв бөглөх хэрэгтэй.

Хэрэв худал мэдүүлбэл, хууль бусаар тэтгэмж авсан хэргээр хариуцлага хүлээнэ.

1 Магадлан тогтоох өдөр, ① Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ ② Ажилгүйдэл тодорхойлох өргөдөл ③ Тамга (stamp тамга болохгүй) авчрах.

2 Ажилгүйдэл тодорхойлох өргөдлийг хар өнгийн бал эсвэл үзгээр бөглөх.

Хэрэв алдаатай бичсэн бол, залруулгын тамга дарах эсвэл гарын үсгээ зурж засаарай.

3 Дараах тохиолдолд орлого олоогүй байсан ч холбогдох хэсэгт үнэн зөв бичээрэй.

(1) **Ажилд орсон (дагалдан, туршилтын хугацаа орно)** тохиолдолд, **ажилд орсон огноо.**

(2) **Үндсэн ажлаас гадуур ажил хийсэн болон ажилд тусалсан бол, тухайн өдөр**

(3) **Цагийн ажил, түр ажил, өдрийн ажил хийсэн бол, ажил хийсэн өдөр**

(эдгээр нь удаан хугацаанд давтагдвал “**ажил эрхлэлт**” гэж үзэх тохиолдол байдаг).

(4) **Хувийн бизнес** эхлүүлсэн (**бэлтгэлийн хугацаа орно**) , **компанийн албан тушаалд дэвшсэн, хөдөө аж ахуй-худалдаа арилжаа гэх мэт гэр бүлийн бизнес эрхэлсэн, гэрээт ажил, төлөөлөн ажил гүйцэтгэсэн, сайн дурын үйл ажиллагаа явуулсан бол тухайн өдөр**

Анхаар

- ★ Ажилд орсон өдөр үндсэн тэтгэмж авах боломжгүй боловч, тодорхой болзол хангавал “хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмж” авах боломжтой (“25 хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмжийн тухай”-г харна уу).
- ★ Үндсэн ажлаас гадуур ажил хийсэн, ажилд тусалсан зэргээр орлого олсон бол, тодорхой шалгуур дээр үндэслэн тооцоолж үндсэн тэтгэмжийн хэмжээг бууруулах, эсвэл олгохгүй байх тохиолдол байдаг. Тодорхой мэдээллийг Hello Work төвийн ажилтнаас лавлаарай.
- ★ Жолооны үнэмлэх эсвэл таныг мөн гэж батлах бусад биеийн байцаалт үзэх шаардлага гарч болзошгүй.

Хүлээн авах дээр дуудах талаар

Ажилгүйдлийг тодорхойлох хүлээн авах цонхонд тэтгэмж авагчийг дуудахдаа хүлээн авахын ажлыг хөнгөвчлөн хүлээх цагийг богиносгох, бичиг баримт андуурч хэвлэхээс сэргийлэх зорилгоор бүтэн нэрээр дууддаг.

Хэрэв янз бүрийн шалтгаанаар бүтэн нэрээр дуудуулахыг хүсэхгүй бол урьдчилан ажилтанд мэдэгдэнэ үү.

Ажилгүйдэл тодорхойлох өргөдөл

(2-р нүүрний анхааруулгыг сайтар уншсаны дараа бөглөөрэй)

※ Маягтын төрөл 11203

1	Ажилгүйдлийн магадлагаа гаргуулах гэж байгаа хугацаанд ажилд орох, ажиллаж байгаа эсвэл үндсэн ажлаас гадуур ажил хийсэн, ажилд тусалсан уу. Ажил хийсэн Ажилд орсон эсвэл ажилласан өдрийг ○, үндсэн ажлаас гадуур ажил эсвэл ажилд тусалсан бол × тэмдэглэгээг Ажил хийгээгүй	4	1	2	3	4	5	6	7	5	сар	1	2	3	4	5	6	7
			8	9	10	11	12	13	14			8	9	10	11	12	13	14
			15	16	17	18	19	20	21			15	16	17	18	19	20	21
			22	23	24	25	26	27	28			22	23	24	25	26	27	28
			29	30	31				29	30	31							
2	Үндсэн ажлаас гадуур ажил хийх эсвэл ажилд тусалсан орлого олсон бол орлогын хэмжээ (хэдэн өдрийн орлого) зэргийг бичих.	Орлого олсон	сар	өдөр	Орлогын хэмжээ	2 0 0 0	Хэдэн өдрийн орлого	2 өдөр										
		Орлого олсон	сар	өдөр	Орлогын хэмжээ	иен	Хэдэн өдрийн орлого	өдөр										
		Орлого олсон	сар	өдөр	Орлогын хэмжээ	иен	Хэдэн өдрийн орлого	өдөр										
3 Ажилгүйдлийн магадлагаа гаргуулах гэж байгаа хугацаанд ажил хайх оролдлого хийсэн үү.																		
Ажил хайх оролдлого хийсэн	(1) Ажил хайх оролдлого хийсэн арга.																	
	Ажил хайсан арга	Өдөр	Байгууллагын нэр	Ажил хайх оролдлогын агуулга														
	(А) Нийтийн хөдөлмөр эрхлэлт тогтвортой байдал хариуцсан газар, орон нутгийн тээврийн товчоо зэрэгт очиж ажлын зөвлөгөө авсан, ажилд зуучуулсан г.м (Б) Хөдөлмөрийн биригд очиж ажлын зөвлөгөө авсан, ажилд зуучуулсан (В) Хөдөлмөр зуучлалын компанид очиж зуучлах ажлын зөвлөгөө авсан г.м (Г) Захиргааны байгууллагуудад очиж ажлын зөвлөгөө авсан, ажилд зуучуулсан	5 / 20	Hello Work төв ○○	Мэргэжлийн зөвлөгөө авсны үр дүнд △△ ХК-д зуучуулан 5 сарын 23-ний өдөр арилцлагад орсон. Үр дүнг хүлээж байгаа. (5 сарын 29-нд хариу гарна.)														
	(2) (1)-с бусад ажил олгогч байгууллагад ажилд орох өргөдөл гаргасан бол доорх хэсэгт бичнэ үү.																	
	Байгууллагын нэр, хэлтэс	Бүртгүүлсэн огноо	Бүртгүүлсэн арга	Ажлын төрөл	Бүртгүүлэх болсон шалтгаан	Бүртгэлийн үр дүн												
	(ХК) □□ аж үйлдвэр	5 / 6	Бичлэн очих	Борлуулалт	(А) Танил зуучлах (Б) Сонин зар Ажлын мэдээллийн сэтгүүл (В) Цахим сүлжээ (Г) Бусад	5 сар 16 өдөр												
	(Утасны дугаар 03-5253-1111)				(А) Танил зуучлах (Б) Сонин зар Ажлын мэдээллийн сэтгүүл (В) Цахим сүлжээ (Г) Бусад	Ажилд авахаас татгалзсан хариу авсан												
	(Утасны дугаар)				(А) Танил зуучлах (Б) Сонин зар Ажлын мэдээллийн сэтгүүл (В) Цахим сүлжээ (Г) Бусад													
	Ажил хайгаагүй	(Шалтгааныг тодорхой бичнэ үү)																
	4 Нийтийн хөдөлмөр эрхлэлт тогтвортой байдал хариуцсан газар эсвэл орон нутгийн тээврийн товчооноос тохирсон ажилд зуучилбал шууд зөвшөөрөх үү.																	
А зөвшөөрнө Б зөвшөөрөхгүй	А-г сонгосон бол, шууд орж чадахгүй шалтгааныг 2-р нүүрний анхааруулгын 8-с сонгож тэмдэглэжэй ○-аар дугуйлаарай.																	
		(А)	(Б)	(В)	(Г)	(Д)	(Е)											
5 Ажилд орсон эсвэл хувийн бизнес эхлүүлсэн, эхлүүлэх төлөвлөгөө байгаа бол бөглөнө.	Ажилд орсон	(1) Нийтийн хөдөлмөр эрхлэлт тогтвортой байдал хариуцсан газар, орон нутгийн тээврийн товчоо зүүнх (2) Орон нутгийн олон нийтийн байгууллага эсвэл хөдөлмөрийн биригд зуучуулан ажилд орсон		(Ажил эрхлэх газар) Оффисын нэр () Байршил ()														
	Хувийн бизнес	сар өдөр ажилд орно (төлөвлөгөөтэй) сар өдөр хувийн бизнес эхлүүлсэн (төлөвлөгөөтэй)		Утасны дугаар ()														
Хөдөлмөрийн даатгалын тухай хууль хэрэгжүүлэх журмын 22-р зүйлийн 1 дэх заалтын дагуу дээрх байдлаар мэдэгдэж байна. Рейва 2 он 5 сар 28 өдөр (Өргөдөл гаргах огноо) ○○																		
Тэтгэмж авагчийн овог нэр Коёо Тароо тамга Тэтгэмж олгох дугаар (2 0 - 1 2 3 4 5 6 - 7																		

(Тогрох хэсэг ○-г тэмдэглэж шаардлагатай мэдээллийг бөглөнө үү.)

※ Байгууллагын бэлтгэл хэсэг	1. Тэтгэмж олгох дугаар											2. Олгогдоогүй тэтгэмжийн ангилал	хоосон үй ологдоогүй тэтгэмжээс бусад 1 ологдоогүй тэтгэмж										3. Хүлээлтийн хугацаа дууссан огноо																
	4. Олгох хугацаа	он	сар	өдөр	5. Үндсэн ажлаас гадуур ажилд тусалсан орлого	сар	өдөр	6. Үндсэн тэтгэмж олгох өдрийн тоо											7. Ажилд орох огноо - маршрут																				
	7. Хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмж олгох өдөр											8. Хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмжтэй тэнцэх тусгай тэтгэмж олгох өдөр											9. Ажилд орох огноо - маршрут																
Дараагийн магадлан тогтоох өдөр цаг										Магадлагаа гаргах хугацаа										※Холбогдох мэдээлэл										Ажилтны тамга									
сар өдөр цагаас цаг хүртэл										Тайлбар																													

◎ **Ажилгүйдэл тодорхойлох өргөдлийг үнэн зөв бөглөцгөө.**

Бөглөх талаар тодорхой тайлбарыг хөдөлмөрийн даатгалын тухай танилцуулга дээр тайлбарлана.

- ① Ажилгүйдлийн магадалгаа гаргуулах хугацаанд ажилд орсон, ажиллаж байгаа, үндсэн ажлаас гадуур ажил хийсэн, ажилд тусалсан бол “ア した”(ア гэсэн)-д ○ тэмдэглэгээ тэмдэглээрэй.

Ажилгүйдлийн магадалгаа гаргуулах хугацаа гэдэг

Зарчмын хувьд, өмнөх магадлан тогтоох өдрөөс энэ удаагийн магадлан тогтоох өдрийн өмнөх өдөр хүртэл хугацааг хэлнэ.

Ажилд орсон эсвэл ажилласан өдөр (○) , үндсэн ажлаас гадуур ажил хийсэн эсвэл ажилд тусалсан бол (×)

15-р хуудасны шаардлагыг харж хуанлид ○ эсвэл × тэмдэглээрэй.

※ **Аль ч тохиолдолд орлого олсон ч олоогүй ч заавал бөглөх хэрэгтэй.**

Мөн ажилд орсон эсвэл ажиллаж байгаа, эсвэл үндсэн ажлаас гадуур ажил, туслах ажил гэдгийг шийдэж чадахгүй бол Hello Work төвийн ажилтнаас лавлаж бичээрэй.

- ② Ажилгүйдлийн магадалгаа гаргуулах хугацаанд үндсэн ажлаас гадуур ажил эсвэл туслах ажил хийж орлого олсон бол уг ажлын орлого, ажилд тусалсан шагнал авсан өдөр болон орлогын хэмжээ, уг орлого нь хэдэн өдрийн хэмжээнийх болохыг заавал бичнэ.

- ③ Ажил хайх үйл ажиллагааны явцыг тодорхой бичнэ. (“ажил хайх үйл ажиллагаа” гэж үзэх болзлын талаар 16-р хуудаснаас харах).

Тодорхой бичих журам дараах байдалтай байна.

- Ажилгүйдлийн магадалгаа гаргуулах хугацаанд ажил хайх оролдлого хийсэн бол (1) хэсгийн тохирох заалтыг бөглөх.
(1) хэсгийн ажил хайх явцаас бусад аргаар ажил олгогчид ажилд орох өргөдөл өгсөн бол (2) хэсгийн тохирох заалтыг бөглөх.
- Ажлаас гарсан шалтгаанаас болж тэтгэмжийн хязгаарлалттай бол, тэтгэмжийн хязгаарлалт дууссаны дараах эхний ажилгүйдлийг магадлан тогтоох өдөр тэтгэмжийн хязгаарлалтын хугацааны үеэр явуулсан ажил хайх үйл ажиллагааны талаар бөглөх.
- (1) хэсэгт (ア) ~ (工) хэсэгт заасан ажил хайх үйл ажиллагаа явуулсан бол тохирох хэсэгт ○ тэмдэглэж “ажил хайсан өдөр”, “байгууллагын нэр” болон “ажил хайх оролдлогын агуулга”-г тодорхой бичээрэй.
(イ) ~ (工)-н хувийн ажилд зуучлах байгууллага, илгээлтийн байгууллага, төрийн байгууллага зэргээр очсон бол “байгууллагын нэр” хэсэгт байгууллагын нэрээс гадна утасны дугаарыг хамт бичих.
- (2) хэсгийн “байгууллагын нэр, хэлтэс” хэсэгт бүртгүүлсэн байгууллагын нэр болон хэлтсийн нэрээс гадна тухайн хэлтсийн утасны дугаарыг хамт бичих.
Мөн “бүртгүүлэх арга” хэсэгт материалаа шуудангаар илгээсэн, биечлэн очсон зэрэг бүртгүүлсэн аргын тухай тодорхой бичнэ.
“Бүртгэлийн үр дүн” хэсэгт, жишээлбэл “одоогийн байдлаар хариугаа хүлээж байгаа (×сар×өдөр хариу гарах төлөвлөгөөтэй)” , “×сар×өдөр ажилд авах (авахгүй)-г мэдэгдэнэ” гэх мэт нөхцөл байдлаа тодорхой бичих.

- ④ Hello Work төвөөс ажилд зуучлахыг зөвшөөрөх бол “ア 応じられる”(ア зөвшөөрнө)-д ○ тэмдэглээрэй.
Зуучлахыг зөвшөөрөх боломжгүй бол “イ 応じられない”(イ зөвшөөрөхгүй)-д ○ тэмдэглэж шалтгааныг арын нүүрний 8-н (ア) ~ (才) -с сонгож ○ тэмдэглээрэй.

- ⑤ Ажилд орох нь тодорхой болсон бол ажилд орох (төлөвлөгөөтэй) огноо, ажилд орох байгууллагын тухай үнэн зөв бөглөөрэй (дагалдан, туршилтын хугацаанд байгаа бол эхний өдрөө бичих).

- ⑥ Магадлан тогтоох өдрийн огноо, тэтгэмж олгох дугаарыг бичих. Тэтгэмж авагчийн овог нэр хэсэгт овог нэрээ бичиж тамга дарах эсвэл гарын үсгээ зурна.

Ажилд орох эсвэл ажиллаж байгаа бол (ажилгүйдэл тодорхойлох өргөдлийн хуанлид тэмдэглэгээ бичих тохиолдол)

- ① Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч болох бол (ажилд орох бол ажилгүйдэл тодорхойлох өргөдлийн 5  хэсгийг бөглөх).
 - ② Ажил олгогч дээр ажилд орж, **1 өдрийн ажлын цаг 4 цагаас дээш бол**.
※гэрээний хугацаа 7 хоногоос дээш хөдөлмөрийн гэрээтэйгээр долоо хоногийн тогтсон ажлын цаг 20 цагаас дээш байхаас гадна долоо хоногийн ажлын өдөр 4 өдрөөс дээш бол хөдөлмөр эрхлээгүй өдрийг оролцуулан ажилд орсон гэж үзнэ.
 - ③ Компанийн албан тушаад дэвшсэн бол (өдөрт ажиллах цаг хамаагүй).
 - ④ Хувийн бизнес эрхлэх бэлтгэл, хувийн бизнес эрхлэх, худалдаа арилжаа • хөдөө аж ахуй гэх мэт гэр бүлийн бизнес эрхлэх, гэрээт ажил, төлөөлөн ажил гүйцэтгэх, гэртээ үндсэн ажлаас гадуур ажил хийх, сайн дурын үйл ажиллагаанд оролцсон бол, зарчмын хувьд **хөдөлмөр эрхэлсэн цаг 1 өдөрт 4 цагаас дээш бол**.
 - ⑤ ④-д дурдсан үйл ажиллагаа явуулж, **1 өдөрт хөдөлмөр эрхэлсэн цаг 4 цагт хүрээгүй боловч, уг ажлыг эрхлэхийн тулд Hello Work төв зэргээс ажилд зуучлахыг шууд зөвшөөрөх боломжгүй улмаар ажил хайх үйл ажиллагаа хийгээгүй бол**.
- ※ ①, ②, ③-ийн тухайд цалин хөлс, шагнал урамшуулал аваагүй байсан ч хөдөлмөр эрхлэх эсвэл ажилласан болно.

Үндсэн ажлаас гадуур ажил хийх эсвэл ажилд туслах (ажилгүйдэл тодорхойлох өргөдлийн хуанлид тэмдэглэгээ бичих тохиолдол)

- ① Ажил олгогч дээр ажилд орсон бол, хувийн бизнес эрхлэх бэлтгэл, хувийн бизнес эрхлэх, худалдаа арилжаа, хөдөө аж ахуй гэх мэт гэр бүлийн бизнес эрхлэх, гэрээт ажил, төлөөлөн ажил гүйцэтгэх, гэртээ үндсэн ажлаас гадуур ажил хийх, сайн дурын үйл ажиллагаанд оролцсон бол, **зарчмын хувьд хөдөлмөр эрхэлсэн цаг 1 өдөрт 4 цагаас доош** (хөдөлмөрийн даатгалын даатгуулагч болох тохиолдлоос бусад) байсан бол.
 - ② Хувийн бизнес эрхлэх бэлтгэл, хувийн бизнес эрхлэх, худалдаа арилжаа • хөдөө аж ахуй гэх мэт гэр бүлийн бизнес эрхлэх, гэрээт ажил, төлөөлөн ажил гүйцэтгэх, гэртээ үндсэн ажлаас гадуур ажил хийх, сайн дурын үйл ажиллагаанд оролцсон бөгөөд 1 өдрийн хөдөлмөр эрхэлсэн цаг 4 цагаас дээш байсан боловч 1 өдөрт оногдох орлогын хэмжээ цалин хөлсний өдрийн хэмжээний хамгийн доод хэмжээнд (*) хүрэхгүй бол.
* 2.574 иен. Уг хэмжээ нь жил бүр 8 сарын 1-д өөрчлөгдөх тохиолдол байдаг.
- ※ Гэртээ үндсэн ажлаас гадуур ажил хийх эсвэл ажилд тусалж орлого олоогүй байсан ч мэдэгдэх шаардлагатай. Мөн үндсэн ажлаас гадуур ажил эсвэл ажилд тусалж орлого олсон бол (өөрийн хөдөлмөрөөр орлого олсон) бол уг орлогын хэмжээн мэдүүлэх шаардлагатай.

13 Ажил хайх үйл ажиллагааны үр дүн гэдэг нь?

Ажил хайх аргын талаар Hello Work төвөөс бэлдсэн арга болон сонины зар, цахим сүлжээгээр ажлын байрны мэдээлэл хайх болон танилаараа зуучлуулах зэрэг олон арга байх боловч үндсэн тэтгэмж авахын тулд **баталгаажуулах боломжтой ажил хайсан үр дүнгийн бүртгэл** шаардлагатай болно. Уг үр дүнгийн бүртгэлийг “**ажил хайх үйл ажиллагааны үр дүн**” гэнэ (ажил хайх үйл ажиллагаа үр дүнтэй байсан гэж хүлээн зөвшөөрөгдөх нөхцөлийн талаар дараагийн хуудаснаас харна уу).

Үндсэн тэтгэмжийн олголт авахын тулд **ажил хайх оролдлого үр дүнтэй гэж хүлээн зөвшөөрөгдөх үйл ажиллагааг, зарчмын хувьд өмнөх магадлан тогтоох өдрөөс энэ удаагийн магадлан тогтоох өдрийн өмнөх өдөр хүртэл хугацаанд хамгийн багадаа 2 удаагаас дээш явуулах шаардлагатай** болно.

Мөн тэтгэмжийн хязгаарлалттай бол тэтгэмжийн хязгаарлалтын хугацаа болон түүний яг дараагийн магадлан олгох хугацааг нийлүүлсэн хугацаанд **ажил хайх үйл ажиллагаа үр дүнтэй гэж хүлээн зөвшөөрөгдөх үйл ажиллагааг хамгийн багадаа 3 удаагаас дээш явуулах шаардлагатай** болно.

14 Ажил хайх үйл ажиллагааны үр дүнд юу орох вэ?

Ажил хайх үйл ажиллагаа үр дүнтэй байсан гэж хүлээн зөвшөөрөгдөх гол нөхцөлүүд доор дурдсаны дагуу байна. **Hello Work төв, сонин, цахим сүлжээ гэх мэтээр ажлын байрны мэдээлэл харсан, танилаасаа гуйж зуучлуулсан зэрэг нь ажил хайх үйл явц үр дүнтэй байсанд тооцогдохгүй.**

- ① Ажлын байранд бүртгүүлэх
- ② Hello Work төв, далайчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөс зохион байгуулдаг ажил мэргэжлийн зөвлөгөө, ажилд зуучлах зэрэг
- ③ Hello Work төв, далайчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөс зохион байгуулдаг төрөл бүрийн сургалт, семинарт оролцох
- ④ Зөвшөөрөл • бүртгэл бүхий хувийн байгууллагаас (ажилд зуучилдаг хувийн хэвшил, ажилчин илгээдэг илгээлтийн байгууллага) зохион байгуулдаг ажлын зөвлөгөө ажилд зуучлах г.м
- ⑤ Зөвшөөрөл • бүртгэл бүхий хувийн байгууллагаас (ажилд зуучилдаг хувийн хэвшил, ажилчин илгээдэг илгээлтийн байгууллага) зохион байгуулдаг ажил хайх үйл ажиллагаа явуулах арга заах семинар зэрэгт оролцох
- ⑥ Олон нийтийн захиргааны байгууллагаас (хараат бус захиргааны байгууллага өндөр настан • хөгжлийн бэрхшээлтэй иргэн • ажил хайгч иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллага, орон нутгийн засаг захиргаа, ажлын байрны талаар мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлдэг компани, сонины компани зэрэг) зохион байгуулдаг ажлын зөвлөгөө г.м
- ⑦ Олон нийтийн захиргааны байгууллагаас (хараат бус захиргааны байгууллага өндөр настан • хөгжлийн бэрхшээлтэй иргэн • ажил хайгч иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллага, орон нутгийн засаг захиргаа, ажлын байрны талаар мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлдэг компани, сонины компани зэрэг) зохион байгуулдаг төрөл бүрийн сургалт • семинар, ганцаарчилсан зөвлөгөө өгдөг байгууллагын танилцуулга зэрэгт суух
- ⑧ Дахин ажилд ороход хувь нэмэр болох улсын шалгалтууд, гэрчилгээжүүлэх шалгалт гэх мэт шалгалт өгөх

※ Ажил хайх үйл ажиллагааны үр дүнд бүртгэгдэх эсэх нь тодорхойгүй бол Hello Work төвөөс лавлаарай.

Эдгээр ажил хайх үйл ажиллагаа үр дүнтэй гэж хүлээн зөвшөөрөгдөх нөхцөлүүд нь аль болох түргэн дахин ажилд ороход ихээхэн түлхэц болох учир, ажил хайх явцдаа идэвхтэй ашиглаарай.

Улмаар өргөдөлд бичсэн ажил хайх үйл ажиллагааны талаар тухайн байгууллагатай холбогдож бодит эсэхийг шалгадаг тул бодит байдалд нийцэхгүй мэдэгдэл нь хууль бусаар тэтгэмж авсан болно.

15 Үндсэн тэтгэмж олголтын тухай

Үндсэн тэтгэмж нь **ажилгүйдлийн магадлагаа гаргуулсны дараа уг тодорхойлсон өдрийн тоогоор** таны бүртгүүлсэн санхүүгийн байгууллагын дансанд **шилжин орно.**

Дансанд шилжин орох нь **ажилгүйдэл магадлан тогтоох өдрийн ойролцоогоор 7 хоногийн дараа** байдаг. (Санхүүгийн байгууллагаас шалтгаалж шилжин орох хугацаа харилцан адилгүй. Мөн бямба, ням гараг зэрэг санхүүгийн байгууллагын амралтын өдөр таарвал уг хугацаагаар шилжин оролт хоцорно).

Түүнчлэн хадгаламжийн данс нь өөрийн нэр дээр байдаг энгийн хадгаламжийн данс (хадгаламжийн данснаас бусад) биш бол шилжүүлэх боломжгүй тул анхаараарай.

Шилжүүлгийн нэр “**コウセイロウドウショウシヨクギョウアンテイキョク** (Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хөдөлмөр эрхлэлт тогтвортой байдал хариуцсан товчоо)” гэж бичигдсэн байна. Банкны дэвтэрт дээрх нэрийн тал хүртэл хэвлэгдэнэ. ※ санхүүгийн байгууллагаас хамаарч өөр байх тохиолдол байдаг.

Анхаар

- ☆ Овог нэр өөрчлөх бол хадгаламжийн нэрээ өөрчилсөн ч тэтгэмж шилжүүлэх боломжгүй тул, шинэ овог нэрээр хийсэн хадгаламжийн дэвтрээ Hello Work төвийн ажилтанд өгөөрэй.
- ☆ Шилжин орсон тэтгэмжийн мөнгөний хэмжээний тухайд, хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээний мөнгөний хэмжээ хадгаламжийн дэвтрийн мөнгөний хэмжээ нь таарч байгаа эсэхийг шалгаарай.
- ☆ Ойлгомжгүй зүйл байвал Hello Work төвийн ажилтнаас лавлаарай.

16 Тэтгэмж авах хугацааг сунгах гэдэг нь?

Үндсэн тэтгэмж авч болох хугацаа нь зарчмын хувьд ажлаас гарсан өдрийн дараах өдрөөс 1 жилийн хугацаатай боловч (9-р хуудас), дараах тохиолдолд тэтгэмжийн хугацааг сунгах боломжтой. Тэтгэмжийн хугацаанд өвчин туссан, бэртэж гэмтсэн, жирэмслэлт, төрөлт, хүүхэд өсгөх (3 наснаас доош), бага сургуульд орохын өмнөх хүүхдийн асаргаа, хамаатан садангийн асаргаа, гэр бүлийн хүн гадаадад томилогдоход цуг явах, тодорхой сайн дурын үйл ажиллагаа зэргээр үргэлжлүүлэн 30-с дээш хоног ажил хийх боломжгүй бол уг ажил хийх боломжгүй өдрийн тоог тэтгэмжийн хугацаанд нэмж болно (тэтгэмжийн хугацаанд нэмж болох хугацаа нь хамгийн уртдаа 3 жил байна).


Тэтгэмжийн хугацааг сунгах бүртгэлийн тухай

Тэтгэмжийн хугацааг сунгах өргөдөл гаргахдаа **үргэлжлүүлэн 30 хоногоос дээш ажил хийх боломжгүй болсон өдрийн дараагийн өдрөөс хойш, аль болох хурдан бүртгэл хийлгэх журамтай** боловч, сунгалт хийсний дараах тэтгэмж авах хугацааны сүүлийн өдөр хүртэл хугацааны дотор байвал өргөдөл гаргах боломжтой. Hello Work төвд доорх бичиг баримтыг өгнө үү.

- 1 “Тэтгэмжийн хугацааг сунгах өргөдөл”
- 2 “Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ”
- 3 “Хугацааг сунгах шалтгааны бодит байдлыг гэрчлэх бичиг”

(Материалыг шуудангаар илгээх эсвэл төлөөний хүн авч ирэх боломжтой ба төлөөний хүн ирэх бол итгэмжлэх бичиг авчрах шаардлагатай).

Жишээлбэл



Тэтгэмж авах хугацааны сунгалт зөвшөөрөгдвөл “Тэтгэмж авах хугацааг сунгасан мэдэгдэл” өгөх ба уг хугацааг сунгасан шалтгаан дуусмагц Hello Work төвд даруй мэдэгдэх хэрэгтэй.

Улмаар сунгалт хийх шалтгаанаас хамаарч эмчийн магадлагаа гэх мэт бичиг баримт шаардлагатай болно.

Тэтгэмж авах эрх тогтоолгосны дараа өвчин болон бэртэл гэмтэл зэргийн улмаас 15 өдрөөс дээш ажиллах боломжгүй болсон бол үндсэн тэтгэмжийн оронд түүнтэй тэнцэх хэмжээний бэртэл гэмтлийн тэтгэмж авах боломжтой байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг “31 өвчин болон бэртэл гэмтлээс шалтгаалж ажил хийх боломжгүй болсон бол?” –г харна уу.

60 наснаас дээш тэтгэвэрт гарсан иргэний тэтгэмжийн хугацааны сунгалтын тухай.

60 наснаас дээш (далайчин бол 50 наснаас дээш) тэтгэвэрт гарсан болон тэтгэвэрт гарсны дараа үргэлжлүүлэн ажиллаж байгаад ажлаас гарч, ажлаас гарсны дараа тодорхой хугацаанд ажил хайх өргөдөл гаргахгүй гэдгээ мэдэгдсэн бол, уг мэдэгдэл гаргасан хугацаагаар (хамгийн уртдаа 1 жил) тэтгэмж авах хугацааг сунгах боломжтой. Өргөдөл хүлээн авах сүүлийн хугацаа, ажлаас гарсан өдрийн дараах өдрөөс 2 сарын дотор байна. Энэ хүсэлтээ Hello Work төв зэрэгт ажлаас гарсан тухай хуудсаа өгөхдөө ажилтанд мэдэгдээрэй (ажил хайх өргөдөл гаргасны дараа бол уг тогтолцоог ашиглах боломжгүй тул анхаараарай).

17 Ажилд зуучлахыг татгалзах зэргээс шалтгаалсан тэтгэмжийн хязгаарлалт гэдэг нь?

Hello Work төв зэрэг байгууллагаас зуучилсан ажилд орох, зааварласан мэргэжлийн сургалтад хамрагдах, Hello Work төвөөс зохион байгуулдаг мэргэжлийн удирдамж авах зэргийг хүндэтгэн үзэх шалтгаангүй татгалзсан бол, эсвэл хувийн шалтгаанаар мэргэжлийн сургалтыг дундаас нь орхисон тохиолдолд, тухайн өдрөөс 1 сарын хугацаанд үндсэн тэтгэмж олгохгүй.

18 Магадлан тогтоох өдөр Hello Work төвд очоогүй бол ?

Магадлан тогтоох өдөр Hello Work төвд очоогүй бол уг магадлан тогтоох өдөр хүртэл хугацаа болон төвд ирээгүй магадлан тогтоох тухайн өдрийн **ажилгүйдлийн магадлалгаа (үндсэн тэтгэмж олголт) гаргуулах боломжгүй болно.**

Мөн дараагийн магадлан тогтоох өдрийн өмнөх өдөр хүртэл Hello Work төвд очиж ажлын зөвлөгөө авах зэрэг ажил хайх үйл ажиллагаа идэвхтэй явуулаагүй бол **дараагийн магадлан тогтоох өдрийн өмнөх өдөр хүртэл хугацаанд оногдох ажилгүйдлийн магадлалгаа гаргуулах боломжгүй болно.**

Доорх жишээг харна уу.

① 10 сарын 15 өдрийн магадлан тогтоох өдөр төвд очилгүй, дараагийн магадлан тогтоох өдөр 11 сарын 12 өдөр очсон тохиолдол

Магадлан тогтоох өдөр (9/17)	Магадлан тогтоох өдөр (10/15)	Магадлан тогтоох өдөр (11/12)	Магадлан тогтоох өдөр (12/10)
Тэтгэмж авч чадахгүй	Тэтгэмж авч чадахгүй	Тэтгэмж авч чадна	
9/17 ~ 10/14	10/15 ~ 11/11	11/12 ~ 12/9	
Төвд ирсэн	Төвд ирээгүй	Төвд ирсэн	Төвд ирсэн

Төвд ирж чадаагүй магадлан тогтоох өдрийн (10/15) дараагийн магадлан тогтоох өдрийн (11/12) өмнөх өдөр (11/11) хүртэл төвд ирэхгүй бол 9 сарын 17 өдрөөс 11 сарын 11 өдөр хүртэл **56 өдрийн тэтгэмж авч чадахгүй.**

② 10 сарын 15 өдрийн магадлан тогтоох өдөр төвд очилгүй, 10 сарын 16 өдрөөс 11 сарын 11 өдрийн хооронд очиж ажлын зөвлөгөө аваад 11 сарын 12 өдрийн магадлан тогтоох өдөр очсон тохиолдол.

Магадлан тогтоох өдөр (9/17)	Магадлан тогтоох өдөр (10/15)	Магадлан тогтоох өдөр (11/12)	Магадлан тогтоох өдөр (12/10)
Тэтгэмж авч чадахгүй	10/16-с тэтгэмж тооцогдоно.	Тэтгэмж авч чадна	
9/17 ~ 10/14	10/16 ~ 11/11	11/12 ~ 12/9	
Төвд ирсэн	Төвд ирээгүй	Төвд ирсэн	Төвд ирсэн

Ажлын зөвлөгөө авахаар төвд ирсэн

9 сарын 17 өдрөөс 10 сарын 15 өдөр хүртэл **29 хоногийн тэтгэмж авч чадахгүй.**

Түүнчлэн 10 сарын 16 өдөр ~ 11 сарын 11 өдрийн хугацаанд зарчмын хувьд 2-с дээш удаа ажил хайх үр дүнтэй үйл ажиллагаа явуулсан байх шаардлагатай.

③ Тэтгэмжийн 3 сарын хязгаарлалттай иргэн магадлан тогтоох өдөр төвд ирэлгүй, 3 сар өнгөрсний дараа ирсэн тохиолдол

	Эхний магадлан тогтоох өдөр (8/27)	Магадлан тогтоох өдөр (9/17)	Магадлан тогтоох өдөр (10/15)	Магадлан тогтоох өдөр (11/12)	Магадлан тогтоох өдөр (12/10)
	Тэтгэмж авах эрх тогтоосон өдөр	Төвд ирээгүй	Төвд ирээгүй	Төвд ирээгүй	Төвд ирсэн
	Ажлаас гарсан	Төвд ирээгүй	Төвд ирээгүй	Төвд ирээгүй	Төвд ирсэн

Хүлээлтийн хугацаа болон тэтгэмжийн хязгаарлалт дуусалгүй, **тэтгэмжид хамрагдахгүй (10-р хуудас).**

19 Магадлан тогтоох өдөр өөрчлөх тухай

Магадлан тогтоох өдөр төвд ирэх боломжгүй бол, доор дурдсан зайлшгүй шалтгаантай тохиолдолд л тусгайлан үзэж магадлан тогтоох өдрийг өөрчилж болно.

Энэ тохиолдолд урьдчилан Hello Work төвд мэдэгдэж зааварчилга авах шаардлагатай.


Магадлан тогтоох өдөр өөрчлөхөд зарчмын хувьд уг шалтгааныг нотлох тодорхойлолт гэх мэт бичиг баримт шаардлагатай болно (шаардлагатай бичиг баримтын талаар Hello Work төвийн хүлээн авахаас зааварчилга аваарай).

Зайлшгүй шалтгаан гэдэг нь

- ☆ Ажилд орох
- ☆ Ажил олгогчтой ярилцлагад орох, сонгон шалгаруулалт, ажилд авах шалгалт г.м
- ☆ Улсын шалгалт, гэрчилгээжүүлэх шалгалт өгөх
- ☆ Hello Work төвийн удирдамжаар сургалтад хамрагдах бол
- ☆ Ажил хийх боломжгүй хугацаа 14 хоногоос дотогш өвчин, бэртэл гэмтэл
- ☆ Гэрлэлтийн байдал
- ☆ Төрөл садангийн асаргаа, биеийн байдал муудсан эсвэл нас барсан, гэрлэлт (төрөл садан бүгд биш, хязгаарлагдсан байна)
- ☆ Дунд сургуулийн сурагч ба түүнээс доош насны хүүхэд сургуульд элсэн орох эсвэл төгсөлтийн ёслол зэрэг болно.

Жишээлбэл

Өвчний улмаас 10 сарын 15 өдрийн магадлан тогтоох өдөр ирж чадалгүй Hello Work төвийн зааврын дагуу 10 сарын 17 өдөр тухайн нөхцөл байдлыг нотлох тодорхойлолт гэх мэт баримт авчирсан тохиолдол



10 сарын 17 өдөр, 9 сарын 17 өдрөөс 10 сарын 16 өдөр хүртэл 30 өдрийн магадалгаа авч, 11 сарын 12 өдөр, 10 сарын 17 өдрөөс 11 сарын 11 өдрийн 26 өдрийн магадалгаа авах боломжтой.

Заасан магадлан тогтоох өдөр төвд ирж чадаагүй бол уг шалтгаан нь дараах ①-с ③-н аль нэг бол, тухайн шалтгааныг нотолсон тодорхойлолт бичгээр дараагийн магадлан тогтоох өдөр нийлүүлээд магадалгаа гаргуулж ч болдог.

Энэ тохиолдолд ч урьдчилан Hello Work төвд мэдэгдэж зааварчилга аваарай.

- ① Ажил хийх боломжгүй хугацаа 14 хоногоос дотогш өвчин, бэртэл гэмтлийн үед (осол гэмтлийн акт)
- ② Hello Work төвийн зуучилсан ажил олгогчтой ярилцлагад орсон бол (ярилцлагад орсон тодорхойлолт)
- ③ Байгалийн гамшиг болон бусад гарцаагүй ослоос (үер, газар хөдлөлт, зам тээврийн осол г.м) шалтгаалан төвд ирж чадаагүй бол (захиргааны байгууллагын тодорхойлолт)

20 Ажилд орох эсвэл хувийн бизнес эхлүүлэх нь тодорхой болсон бол ?

Ажилд орох (туршилтын хугацаа, дадлагын хугацаа, цагийн ажил орно) эсвэл хувийн бизнес эхлүүлэх нь тодорхой болсон бол зарчмын хувьд ажилд орох эсвэл хувийн бизнес (хувийн бизнес эхлүүлэхийн тулд бэлтгэлийн хугацаа байгаа бол бэлтгэл) эхлүүлэх өдрийн өмнөх өдөр Hello Work төвд ирж ажилгүйдэл тодорхойлох өргөдөл өгч ажил эрхлэлтийн тухай мэдэгдэл хийн ажилгүйдлийн магадалгаа гаргуулаарай.

Ажил эрхлэлтийн талаар мэдэгдэл гаргахад шаардагдах зүйлс

- ☐ Тэтгэмж авагчийн гэрчилгээ
- ☐ Ажилгүйдэл тодорхойлох өргөдөл
- ☐ Ажилд орсон тухай тодорхойлолт

Улмаар дахин ажилд орсны тэтгэмж авах болзлыг хангасан гэж үзвэл ажилгүйдлийн магадалгаа хийсний дараа өргөдөл бичих цаас өгнө.

※ Хөдөлмөрийн даатгалын танилцуулга хүртэл ажилд орох нь тодорхой болсон (ажилд орсон өдөр нь хөдөлмөрийн даатгалын танилцуулгаас өмнө огноотой) бол, уг “Гарын авлага (Шиори)” болон танилцуулгад ирэхдээ авчраарай гэж заасан зүйлсийн хамт ажилд орохын өмнөх өдөр Hello Work төвд ирж ажил эрхлэлтийн талаар мэдэгдэл гаргана.

※ Ажилд орох өдрөөс өмнө магадлан тогтоох өдөр тогтоогдсон бол, тухайн өдөр Hello Work төвд ирж ажилгүйдлийн магадалгаа гаргуулах шаардлагатай.

※ Hello Work төвд ирж бүртгэл хийлгээгүй тохиолдолд дахин ажилд орсны тэтгэмж гэх мэт тэтгэмж авах хүсэлт гаргах боломжгүй болох тул анхаараарай.

21 Дахин ажилд орсон тэтгэмжийн тухай

Үндсэн тэтгэмжийн тэтгэмж тодорхойлсон өдрийн 3-ний 1-с дээш тэтгэмж олгох өдөр үлдэж, тогтвортой ажилд орон тэтгэмж олгох бүх болзлыг хангавал дахин ажилд орсон тэтгэмж авах боломжтой.

Тэтгэмж олгогдох хэмжээ нь тэтгэмж тодорхойлсон өдрийн тооны 3-ний 1-с дээш үлдсэн бол үлдэгдэл өдрийн 60%, 3-ний 2-с дээш үлдсэн бол 70%-р үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээг үржүүлсэн мөнгөний хэмжээ байна.

Тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо	Тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо		Дахин ажилд орсон тэтгэмжийн хэмжээ
	Олгогдох хувь 60%	Олгогдох хувь 70%	
90 өдөр	30 өдрөөс дээш	60 өдрөөс дээш	$\begin{array}{ccc} \text{Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ} & \times & \text{Тэтгэмж тодорхойлсон өдрийн үлдэгдэл өдөр} \\ & & \times \begin{array}{l} 60\% \\ 70\% \end{array} \\ & & \text{эсвэл} \end{array}$ (※дээд хязгаартай) (1 иен хүрэхгүй бутархайг хаяна)
120 өдөр	40 өдрөөс дээш	80 өдрөөс дээш	
150 өдөр	50 өдрөөс дээш	100 өдрөөс дээш	
180 өдөр	60 өдрөөс дээш	120 өдрөөс дээш	
210 өдөр	70 өдрөөс дээш	140 өдрөөс дээш	
240 өдөр	80 өдрөөс дээш	160 өдрөөс дээш	
270 өдөр	90 өдрөөс дээш	180 өдрөөс дээш	
300 өдөр	100 өдрөөс дээш	200 өдрөөс дээш	
330 өдөр	110 өдрөөс дээш	220 өдрөөс дээш	
360 өдөр	120 өдрөөс дээш	240 өдрөөс дээш	

※ Дахин ажилд орсон тэтгэмжийг тооцоолохдоо үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээнд дээд хязгаар байдаг.

○ Ажлаас гарсан үеийн нас 60-с доош бол **6,195 иен**

○ Ажлаас гарсан үеийн нас 60 ~ 65 хүртэл **5,013 иен**

(Үндсэн тэтгэмжийн хэмжээ жил бүр 8 сарын 1 өдөр өөрчлөгддөг)

Дахин ажилд орсон тэтгэмж авсан бол, тэтгэмжийн хэмжээг үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээнд хувааж гарсан тоотой тэнцэх хэмжээний үндсэн тэтгэмж олгосон гэж үзнэ.

“Тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо” гэдэг нь

Тэтгэмж тодорхойлсон өдрийн тооноос ижил шаардлагад үндэслэн тогтоосон үндсэн тэтгэмж авсан өдрийг хасах, эсвэл бэртэл гэмтлийн тэтгэмж, ажил эрхлэлтийн тэтгэмж, дахин ажилд орсны тэтгэмж авсны улмаас үндсэн тэтгэмж авсан гэж үзсэн өдрийн тоог хассан өдрийн тоог хэлнэ.

※ **Тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо нь ажилд орсон өдрөөс тэтгэмж авах хугацаа дуусах огноо хүртэлх өдрийн тоог давах тохиолдолд, ажилд орсон өдрөөс тэтгэмж авах хугацаа дуусах өдөр хүртэлх өдрийн тоо нь тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо болно.**

Түүнчлэн тэтгэмжийн хязгаарлалтын хугацаанд байхдаа ажилд орж тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо нь тэтгэмжийн хязгаарлалтын хугацааны сүүлийн өдрийн дараах өдрөөс тэтгэмж авах хугацаа дуусах өдөр хүртэлх өдрийн тоог давах тохиолдолд, тэтгэмжийн хязгаарлалтын хугацааны сүүлийн өдрийн дараах өдрөөс тэтгэмж авах хугацаа дуусах өдөр хүртэлх өдрийн тоо нь тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо болно.

Дахин ажилд орсон тэтгэмж олгох болзол

Дараах ①-с ⑧ хүртэлх болзлыг бүгдийг хангавал дахин ажилд орсны тэтгэмж авах боломжтой.

Түүнчлэн бие даасан гэж хүлээн зөвшөөрөх тодорхой шаардлагын дагуу бизнесээ эхлүүлсэн бол дахин ажилд орсон тэтгэмж олгогдох тохиолдол байдаг (энэ тохиолдолд тэтгэмж олгох нөхцөлийн талаар Hello Work төвийн ажилтнаас лавлаарай).

Доорх болзлыг бүгдийг хангасан байх

① Ажилд орох өдрийн өмнөх өдөр хүртэл ажилгүйдлийн магадлагаа гаргуулж үндсэн тэтгэмжийн тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо нь тэтгэмж тодорхойлсон өдрийн тооны 3-ний 1-с илүү байх

(тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо нь ажил орох өдрөөс тэтгэмж авах хугацаа дуусах огноо хүртэлх өдрийн тоог давах бол ажилд орсон өдрөөс тэтгэмж авах хугацаа дуусах өдөр хүртэлх өдрийн тоо нь тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо болно)※тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тооны тухайд дээрх “тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо” гэдгийг харах.

② 1 жилээс дээш хугацаатайгаар ажил хийх нь тодорхой гэдэг нь тогтоогдсон байх

(Хөдөлмөр эрхлэх хугацаа нь 1 жилээс доош байхаар тогтоогдож хөдөлмөрийн гэрээг сунгахтай холбогдуулан тодорхой зорилго биелүүлэх болзолтой тохиолдолд “1 жилээс дээш хугацаатайгаар ажил хийх нь тодорхой” гэдэгт хамрагдахгүй)

③ Хүлээлтийн хугацаа дууссаны дараа ажилд орох

④ Ажлаас гарсан шалтгаанаас хамаарч тэтгэмжийн хязгаарлалттай бол хүлээлтийн хугацаа дууссаны дараах 1 сарын хугацаанд Hello Work төв эсвэл зөвшөөрөл, мэдэгдэлтэй ажил зуучлах байгууллагаар (хөдөлмөрийн бирж) зуучлуулан ажилд орсон байх

⑤ Ажлаас гарахаас өмнөх ажил олгогч дээр дахин ажилд ороогүй байх

(хөрөнгө · санхүүжилт · хүний нөөц · гүйлгээ зэргээс үзэхэд, ажлаас гарахаас өмнөх ажил олгогчтой гүнзгий холбоотой ажил олгогч ч орно)

⑥ Ажилд орохоос өмнөх 3 жилийн хугацаанд дахин ажилд орсны тэтгэмж эсвэл байнгын ажилд орох бэлтгэлийн тэтгэмж аваагүй байх

⑦ Тэтгэмж авах эрх тогтоолгохоос (ажил хайх өргөдөл гаргах) өмнөөс ажилд орох нь тодорхой болсон ажил олгогч дээр ажилд ороогүй байх

⑧ Зарчмын хувьд хөдөлмөрийн даатгалын даатгуулагчийн болзлыг хангасан нөхцөлтэйгөөр ажилд орох

(жишээлбэл итгэмжлэлийн гэрээ, ажил даатгасан гэрээ зэрэг нь хөдөлмөрийн даатгалын даатгуулагчид хамаарахгүй)

※Тэтгэмж олгохоор тогтсон өдрөөс ойролцоогоор 1 долоо хоногийн дараа дансанд шилжин орно. Өргөдлийн агуулгыг шалгах явцаас хамаарч тэтгэмж олгох шийдвэр гаргахад хугацаа шаардагдах тохиолдол байдаг.


“Hello Work төв зэргээс зуучилж ажилд орох” гэдэг нь

Hello Work төв зэргээр зуучлуулан ажил олгогчтой ярилцлага хийн ажилд орсон тохиолдлыг хэлнэ. Hello Work төвийн нээлттэй ажлын байр болон ажлын байрны мэдээллийн сэтгүүл зэргээс ажил хайж **өөрөө ажилд орох өргөдлөө өгч ажилд орсон бол “Hello Work төв зэргээс зуучилж ажилд орсон” гэж үзэхгүй** (Ажилд зуучлах байгууллагаар зуучлуулсан тохиолдолд ч адил).

22 Дахин ажилд ороход олгодог тэтгэмжийн давуу талыг ашиглая


Дахин ажилд орсны тэтгэмж нь хурдан ажилд орвол тэтгэмж олгох хувь **60%→70% болж өсдөг.**

- Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ нь 4000 иен, тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо 90 өдөр, тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо 60 өдөр байхад ажилд орсон тохиолдол



- Тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо 90 өдөрбайхад үндсэн тэтгэмжийн үлдэгдэл өдрийн тоо 60 өдөр (3-ний 2-с илүү) учир дахин ажилд орсон тэтгэмж олгох хувь 70 % болно.
- Дахин ажилд орсон тэтгэмжийн мөнгөний хэмжээ 4.000 иен $\times$ 60 өдөр $\times$ **70%** = 168,000 иен болно.

- Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ 4,000 иен, Тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо 90 байхад тэтгэмжийн үлдэгдэл өдрийн тоо 59 өдөр байхад ажилд орсон тохиолдол



- Тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо 90 өдөр байхад үндсэн тэтгэмжийн үлдэгдэл өдрийн тоо 59 өдөр (3-ний 1-с илүү) учир дахин ажилд орсон тэтгэмж олгох хувь **60 %** болно.
- Дахин ажилд орсон тэтгэмжийн мөнгөний хэмжээ 4.000 иен $\times$ 59 өдөр $\times$ **60%** = 141,600 иен болно.

23 Дахин ажилд орсон тэтгэмж авах бүртгэл гэдэг нь?

Дахин ажилд орсон тэтгэмж авах өргөдлийн бүртгэлийн тухай

Өргөдөл гаргах хугацаа, ажилд орсон өдрийн дараах өдрөөс 1 сарын дотор байна.

Дахин ажилд орсон тэтгэмж авах өргөдөл гаргахдаа дараах бичиг баримтыг Hello Work төвд өгнө.

- 1 Дахин ажилд орсон тэтгэмж авах өргөдөл (Ажил олгогчийн тодорхойлолт шаардлагатай)
 - 2 Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ
 - 3 Бусад, Hello Work төвөөс шаардсан бичиг баримт
- ※ Материалаа шуудангаар ирүүлж болно.

Анхаар

Hello Work төвд ажилд орох мэдэгдэл гаргахгүй бол дахин ажилд орсны тэтгэмж авах өргөдлийн бүртгэл хийх боломжгүй.

Түүнчлэн дахин ажилд орсны тэтгэмж авбал, адилхан шалтгаанаар өндөр настны дахин ажилд орсны тэтгэмж олгогдохгүй. Тодорхой мэдээллийг “36 Үргэлжлүүлэн ажилласны тэтгэмжийн тухай”-г харах.

24 Дахин ажилд орсон тэтгэмж авсаны дараа ч олгодог тэтгэмж байдаг.

Ажилд түргэн орж дахин ажилд орсны тэтгэмж авсан иргэн нь үргэлжлүүлэн уг ажилдаа 6 сараас дээш ажиллахаас гадна 6 сарын хугацаанд төлөгдсөн цалин хөлс нь хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авахын өмнөх цалин хөлстэй харьцуулахад багассан бол **хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тэтгэмж** авах боломжтой.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тэтгэмж олгох болзол

Дараах болзлуудыг бүгдийг хангасан байх шаардлагатай.

- ① Дахин ажилд орсны тэтгэмж авдаг байх.
- ② Дахин ажилд орсон тэтгэмж авч ажилд орсон өдрөөс тухайн байгууллагад үргэлжлүүлэн 6 сараас дээш ажилласан байх.
※ Ажил олгогчийн шаардлагаар томилогдон ажиллаж байсан ч дахин ажилд орсон тэтгэмж авч ажилд орсон өдрөөс 6 сар болохоос өмнө хөдөлмөрийн даатгалын даатгуулагчийн эрхээ алдсан тохиолдолд уг тэтгэмжийг авч чадахгүй.
(хувийн бизнес эхлүүлээд дахин ажилд орсны тэтгэмж олгогдсон бол, уг тэтгэмжийг авч чадахгүй.)
- ③ Дахин ажилд орсон тэтгэмж авч ажилд орсон өдрөөс 6 сарын хугацаанд төлөгдсөн цалин хөлсний 1 өдрийн хэмжээ (А) нь ажлаас гарахаас өмнөх өдөр тутмын цалин хөлсний хэмжээ (В)-с бага байх
(А ба В-н зарчмыг тооцоолох арга р 6-н 14-г харна уу.)
※ Ажлаас гарахаас өмнөх өдөр тутмын цалин хөлсний хэмжээ нь цалингийн хамгийн доод хэмжээ байх бол дахин ажилд орсны дараа 6 сарын цалин хөлсний 1 өдрийн хэмжээ нь ажлаас гарахаас өмнөх өдөр тутмын цалин хөлсний хэмжээнээс доогуур байх учиргүй тул уг тэтгэмж олгогдохгүй.

Олгогдох тэтгэмжийн хэмжээний тухай

Олгогдох хэмжээ $= (B-A) \times$ дахин ажилд орсон өдрөөс 6 сарын хугацаанд цалин хөлсний төлбөрийн тооцооны суурь болсон өдрийн тоо (сарын цалингийн системтэй тохиолдолд хуанлийн хоног, өдрийн болон цагийн цалингийн системтэй тохиолдолд ажилласан өдрийн тоо)

Гэхдээ дараах дээд хэмжээ байдаг.

Дээд хэмжээ : Үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ (※1) $\times$ үндсэн тэтгэмжийн тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоотой тэнцэх өдөр (※2) $\times$ 30%(※3)

※1 үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээ нь дахин ажилд орсон тэтгэмжтэй адилхан дээд хэмжээтэй.

※2 дахин ажилд орсон тэтгэмж авахын өмнөх тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо.

※3 дахин ажилд орсон тэтгэмжийн тэтгэмж олгох хувь нь 60 % бол 40% байна.

- ☐ 60 нас хүрэлгүй ажлаас гарч, ажлаас гарах үеийн цалин нь сарын цалингийн системтэй 300 мянган иен, үндсэн тэтгэмж нь 5,687 иен байсан иргэн нь тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо 90 өдөр байхад дахин ажилд орж, дахин ажилд орсон тэтгэмж авах.

Дахин ажилд орсны дараа 6 сарын цалин нь сарын цалингийн системтэй 285 мянган иен болсон тохиолдолд.

- ☐ Ажлаас гарахаас өмнөх өдөр тутмын цалин хөлсний хэмжээ нь 10,000 иен (B), дахин ажилд орсны дараах 6 сарын хугацааны цалин хөлсний 1 өдрийн хэмжээ нь 9,500 иен (A) байна.
- ☐ Цалин хөлс төлөх суурь өдрийн тоо нь сарын цалингийн системтэй учир хуанлийн хоног (183 өдөр гэж үзнэ) байна.
- ☐ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тэтгэмжийн мөнгөн дүнг томъёогоор тооцоолох юм бол $(10,000 \text{ иен} - 9,500 \text{ иен}) \times 183 \text{ өдөр} = 91,500 \text{ иен}$ болно.
- ☐ Энэ тохиолдолд дээд хэмжээ нь доор тооцоолсны дагуу байх тул 91,500 иен олгогдоно.
 $5,687 \text{ иен} \times 90 \text{ өдөр} \times 30\% = 153,549 \text{ иен}$

Өргөдөл гаргах тухай

Өргөдөл гаргах хугацаа нь ажилд орсон өдрөөс хойш 6 сар болсон өдрийн дараах өдрөөс 2 сарын дотор байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тэтгэмжийн өргөдөл гаргах бол доорх бичиг баримтыг Hello Work төв зэрэгт өгнө үү.

- 1 Өргөдлийн маягт (ажил олгогчийн тодорхойлолт шаардлагатай)
 - 2 Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ
 - 3 Ирцийн бүртгэлийн хуулбар, цалингийн дэвтэр гэх мэт Hello Work төвөөс шаардсан бичиг баримт
- ※Материалаа шуудангаар ирүүлж болно.

25 Хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмжийн тухай

Ажилгүй байхдаа цагийн ажил гэх мэт 1 жилээс дээш ажиллах шинжгүй ажилд орсон (дахин ажилд орсны тэтгэмжид хамаарахгүй) тохиолдолд, уг ажлын өдрийн хувьд, бүх болзлыг хангавал хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмж авах боломжтой.

Түүнчлэн уг хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмж авсан ч дараа нь тухайн ажил нь тогтвортой ажил болсон гэж хүлээн зөвшөөрөгдвөл дахин ажилд орсон тэтгэмжид хамрагдах боломж байдаг.

Энэ тохиолдолд тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо нь “тогтвортой ажилд орсон” өдрийн өмнөх өдрөөр шийдвэрлэгдэнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмжийн хэмжээ

Ажлын өдөр бүр үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээний 30%-д тэнцэх хэмжээний (1 иенээс бага бутархайг хаяна) тэтгэмж авах боломжтой.

※ Хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмжийг тооцоолох үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээнд дээд хэмжээ байна.

- Ажлаас гарсан үеийн нас 60 хүрээгүй иргэн 6,195 иен
- Ажлаас гарсан үеийн нас 60-с дээш 65 хүрээгүй иргэн 5,013 иен

(Үндсэн тэтгэмжийн дээд хэмжээ нь жил бүр 8 сарын 1 өдөр өөрчлөгдөх тохиолдолд байдаг.)

Хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмж авсан өдрийн тухайд, үндсэн тэтгэмж авсан гэж үзнэ.

Дараах болзлыг бүгдийг хангасан байх шаардлагатай

- ① Ажилд орсон өдрийн өмнөх өдөр үндсэн тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо нь тэтгэмж тодорхойлсон өдрийн 3-ний 1-с дээш буюу 45 хоногоос дээш байх.
- ② Дахин ажилд орсон тэтгэмжид хамрагдахгүй ажилд орсон байх.
- ③ Хүлээлтийн хугацаа дууссаны дараах ажил эрхлэлт байх.
- ④ Ажлаас гарсан шалтгаанаас үүдэн тэтгэмжийн хязгаарлалттай бол, хүлээлтийн хугацаа дууссанаас хойш 1 сарын хугацаанд Hello Work төв, эсвэл зөвшөөрөл • мэдэгдэл бүхий ажил зуучлах байгууллагаар (хөдөлмөрийн бирж) зуучлуулж ажилд орсон байх.
- ⑤ Ажлаас гарахаас өмнөх ажил олгогч дээр дахин ажилд ороогүй байх.
(хөрөнгө · санхүүжилт · хүний нөөц · гүйлгээ зэргээс үзэхэд ажлаас гарахаас өмнөх ажил олгогчтой гүнзгий холбоотой ажил олгогч ч орно)
- ⑥ Тэтгэмж авах эрх тогтоохоос өмнө (ажил хайх өргөдөл гаргах) ажилд орох нь тодорхой байсан ажил олгогч дээр ажилд ороогүй байх.

Хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмж хүсэх өргөдөл гаргах тухай

4 долоо хоногт нэг удаа болдог ажилгүйдлийг магадлан тогтоох өдөр өмнөх магадлан тогтоох өдрөөс энэ удаагийн магадлан тогтоох өдрийн өмнөх өдөр хүртэлх өдрүүдийн талаар магадлалгаа тогтоологхдоо “хөдөлмөр эрхлэлтийн тэтгэмжийн өргөдөл”, “хөдөлмөрийн даатгал авагчийн гэрчилгээ” болон “ажилд орсон нь үнэн болохыг тодорхойлох бичиг баримт”-г цуг өгнө.

※ Ажилд орсноос хойш ажилгүйдлийн магадлалгаа шаардлагагүй болсон иргэний хувьд, тэтгэмж хүсэх өргөдлөө төлөөний хүн (итгэмжлэл шаардлагатай) эсвэл шуудангаар ирүүлж болно. Ажил олгогчийн тодорхойлолт шаардлагатай.

26 Байнгын ажилд орох бэлтгэлтйн тэтгэмжийн тухай

Доорх аль нэгд хамаарах иргэн бөгөөд үндсэн тэтгэмжийн тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо нь тэтгэмж тодорхойлсон өдрийн тооны 3-ний 1-д хүрэхгүй хугацаанд Hello Work төв эсвэл зөвшөөрөл, мэдэгдэл бүхий ажил зуучлах байгууллагаар зуучлуулж тогтвортой ажилд орон, тэтгэмж олгох бүх болзлыг хангасан тохиолдолд олгогддог тэтгэмж юм.

- 45 наснаас дээш хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээний тухай хуулийг үндэслэн дахин ажилд орохыг дэмжих төлөвлөгөөнд хамрагдах иргэн
- Хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд ажилд ороход хүндрэлтэй иргэн

Байнгын ажилд орох бэлтгэлтийн тэтгэмжийн хэмжээ

Тэтгэмжийн хэмжээ нь, 90 (тэтгэмж тодорхойлсон өдрийн тэтгэмж олгох үлдэгдэл өдөр нь 90-д хүрээгүй бол үлдэгдэл өдөртэй тэнцэх тоо. Уг тоо нь 45-с бага бол 45)-д үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээг үржүүлж гарсан хэмжээний 10-ний 4 болно (1 иенээс бага бутархайг хаяна).

Улмаар тэтгэмж тодорхойлсон өдрийн тоо нь 270 өдрөөс дээш тэтгэмж авагчийн хувьд нэгэн жигд 36 өдрийнх байна.

※ Байнгын ажилд орох бэлтгэлийн тэтгэмжийг тооцоолоход үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээнд дээд хэмжээ байна.

- Ажлаас гарсан үеийн нас 60 хүрээгүй иргэн **6,195 иен**
- Ажлаас гарсан үеийн нас 60-с дээш 65 хүрээгүй иргэн **5,013 иен**

(Үндсэн тэтгэмжийн дээд хэмжээ нь жил бүр 8 сарын 1 өдөр өөрчлөгдөх тохиолдолд байдаг.)

Дараах болзлыг бүгдийг хангасан байх шаардлагатай

- ① Үндсэн тэтгэмжийн тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо нь тэтгэмж тодорхойлсон өдрийн 3-ний 1-с бага байх.
- ② Hello Work төв, эсвэл зөвшөөрөл • мэдэгдэл бүхий ажил зуучлах байгууллагаар зуучлуулж ажилд орсон байх.
- ③ 1-с дээш жил үргэлжлүүлэн ажиллах нь тодорхой байх.
- ④ Ажлаас гарахаас өмнөх ажил олгогч дээр дахин ажилд ороогүй байх.
- ⑤ Хүлээлтийн хугацаа дууссаны дараа ажилд орсон байх.
- ⑥ Тэтгэмжийн хязгаарлалт дууссаны дараа ажилд орсон байх.
- ⑦ Зарчмын хувьд, ажилд орсон өдөр тэтгэмж олгох өдөр үлдсэн байх.
- ⑧ Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч болох нөхцөлтэйгөөр ажилд орох.
- ⑨ Ажилд орохоос өмнөх 3 жилийн дотор хөдөлмөр эрхлэхдээ дахин ажилд орсны тэтгэмж эсвэл байнгын ажилд орох бэлтгэлийн тэтгэмж аваагүй байх.
- ⑩ Дахин ажилд орсон тэтгэмж авах боломжгүй байх.

※Тэтгэмж олгохтой холбоотой судалгаа явуулах үед уг ажил олгогч дээр ажиллаж байх шаардлагатай.

Байнгын ажилд орох бэлтгэлийн тэтгэмж хүсэх өргөдлийн тухай

Өргөдөл гаргах хугацаа нь ажилд орсон өдрийн дараах өдрөөс 1 сарын дотор байна.

Байнгын ажилд орох бэлтгэлийн тэтгэмж хүсэх өргөдөл гаргах бол доорх бичиг баримтыг Hello Work төв зэрэгт өгнө үү.

1 Байнгын ажилд орох бэлтгэлийн тэтгэмж хүсэх өргөдлийн маягт (ажил олгогчийн тодорхойлолт шаардлагатай)

2 Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ

3 Бусад, Hello Work төвөөс шаардсан бичиг баримт

※Материалаа шуудангаар ирүүлж болно. Тэтгэмж олгох • Олгохгүйг тогтоохын тулд тодорхой судалгааны хугацаа (1 сар орчим) шаардана.

27 Бусад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тэтгэмжийн тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад тэтгэмжид нүүлгэн шилжүүлэх зардал, өргөн хүрээнд ажил хайх үйл ажиллагаа явуулахад зориулсан зардал зэрэг байдаг.

Нүүлгэн шилжүүлэх зардлын тухай

Нүүлгэн шилжүүлэх зардал гэдэг нь тэтгэмж авагч Hello Work төв, тодорхой орон нутгийн олон нийтийн байгууллага эсвэл ажилд зуучлах байгууллагын зуучилсан ажилд орохын тулд эсвэл Hello Work төвийн даргын зааварласан олон нийтийн мэргэжлийн сургалтад суухын тулд оршин суух газраа сольсон тохиолдолд, Hello Work төвийн дарга шаардлагатай гэж хүлээн зөвшөөрвөл олгогддог тэтгэмж юм..

Нүүлгэн шилжүүлэх зардлыг дараах хүн авах боломжтой.

Үндсэн тэтгэмж авч байгаа иргэн Hello Work төв, тодорхой орон нутгийн олон нийтийн байгууллага эсвэл ажилд зуучлах байгууллагын зуучилсан ажилд орохын тулд эсвэл Hello Work төвийн даргын зааварласан олон нийтийн мэргэжлийн сургалтад суухын тулд оршин суух газраа солих тохиолдолд, дараах (1), (П)-н аль алинд хамаарах бол тэтгэмж авна.

(1) Хүлээлтийн хугацаа өнгөрсний дараа ажилд орох эсвэл сургалтад хамрагдах гэж байгаа бол, хариуцдаг Hello Work төвийн дарга нь оршин суух газраа солих хэрэгтэй гэж үзсэн тохиолдолд.

Улмаар доорх аль нэгд хамрах бол оршин суух газраа солих шаардлагатай гэж хүлээн зөвшөөрөгдсөн гэж үзнэ.

- i) Ердийн тээвэр ашиглаж эсвэл ердийн тээврийн хэрэгсэл ашиглан зорчиход хоёр талын аяллын цаг 4 цагаас дээш байх бол
- ii) Тээврийн хэрэгслийн эхний (сүүлийн) зорчих хэрэгсэл муу, зорчиход ихээхэн саад бэрхшээлтэй бол
- iii) Ажилд орсон байгууллага эсвэл сургалтад суух байгууламжийн онцлог эсвэл ажил олгогчийн хүсэлтээр нүүн шилжихээс аргагүй болсон бол.

(П) Холбогдох ажил эсвэл олон нийтийн мэргэжлийн сургалтад суух тухайд, ажилд орох бэлтгэлийн мөнгө болон бусад нүүлгэн шилжүүлэхэд шаардлагатай зардал нь ажилд олгогч, сургалтын төвийн дарга болон бусад этгээдүүдээс төлөгдөөгүй, эсвэл төлөгдсөн төлбөрийн хэмжээ нь нүүлгэн шилжүүлэх зардлын төлбөрт хүрээгүй бол.

Дээр дурдсан (1), (П)-д хамаарсан ч ажилд авсан хугацаа нь 1 жилд хүрэхгүй бол, мөчлөгөөр ажилд ордог зуршилтай иргэнийг ажлаас гарахаас өмнөх байдалтай адилхан ажилд авсан тохиолдол болон ажилд зуучлахаас татгалзах зэргээс үүдэн тэтгэмжийн хязгаарлалт тогтоолгосон бол уг тэтгэмжийн хязгаарлалтын хугацаа өнгөрөхөөс өмнө ажилд орох эсвэл сургалтад суух болсон зэрэг тохиолдолд нүүлгэн шилжүүлэх зардал олгогдохгүй.

(Өргөдөл гаргах талаар Hello Work төвийн ажилтнаас лавлаарай).

Ажил хайх оролдлогыг дэмжих зардлын тухай

Ажил хайх оролдлогыг дэмжих зардал гэдэг нь өргөн хүрээнд ажил хайх оролдлогод зориулсан зардал, богино хугацааны сургалтад хамрагдах зардал, ажил хайх үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ ашиглах зардлаас бүрдэх ба тэтгэмж авагч нь ажил хайх оролдлого хийхтэй холбоотой дараах ① ~ ③-н аль нэгт хамаарах зүйлийг хийвэл, Hello Work төвийн дарга шаардлагатай гэж үзвэл олгогдоно.

- ① Hello Work төвөөс зуучлан өргөн хүрээнд ажил хайх оролдлого гаргавал
(Өргөн хүрээнд ажил хайх оролдлогод зориулсан зардал)
- ② Hello Work төвийн удирдамжийн дагуу богино хугацааны сургалтад суух бол
(Богино хугацааны сургалтад хамрагдах зардал)
- ③ Ажил хайх үйл ажиллагааг хөнгөвчлөхийн тулд хүүхэд харах үйлчилгээ гэх мэт үйлчилгээг ашиглах бол
(Ажил хайх оролдлоготой холбоотой үйлчилгээ ашиглах зардал)

【Өргөн хүрээнд ажил хайх оролдлогод зориулсан зардал】

Өргөн хүрээнд ажил хайх оролдлого хийхэд зориулсан зардлын тэтгэмж авч болох нөхцөл нь Hello Work төвөөс зуучлан өргөн цар хүрээнд газар нутаг дамжин ажил хайх оролдлого хийж дараах (1), (2)-н хоёуланд харгалзах иргэн.

(1) Зуучилсан ажил олгогч нь холбогдох тэтгэмж авагчид тохиромжтой гэж үзсэн харьяалал бүсээс гадна байрладаг ажил олгогчийн ажлын байранд хамааралтай тогтмол ажил олгогч байх.

(2) Төмөр замын төлбөр, усан онгоцны төлбөр, агаарын болон автомашины төлбөрийн тооцооны үндэс болох зай нь төмөр замаар 2 талын 200 км (усан зам ба хуурай зам бол тус тусын 4-ний 1 км-г төмөр замын 1 км гэж үзнэ)-с дээш байх.

Дээрх (1) болон (2)-д хамаарах тэтгэмж авагчийн хувьд, дараах нөхцөлд хамаарахгүй бол өргөн хүрээнд ажил хайх оролдлогод зориулсан зардал олгогдохгүй.

- i) Хүлээлтийн хугацаа өнгөрсний дараа өргөн хүрээнд ажил хайх оролдлого хийсэн бол
- ii) Өргөн хүрээнд ажил хайх оролдлогод зарцуулсан зардлыг цаад байгууллага нь төлөөгүй бол эсвэл төлөгдсөн төлбөр нь зарцуулсан зардлын хэмжээнд хүрэхгүй байх

Улмаар дээрх i), ii)-с гадна ажилд зуучлахаас татгалзах зэргээс үүдэн тэтгэмжийн хязгаарлалт тогтоолгосон бол уг тэтгэмжийн хязгаарлалтын хугацаа өнгөрөхөөс өмнө өргөн хүрээнд ажил хайх оролдлого хийж эхлүүлсэн гэх мэт тохиолдолд өргөн хүрээнд ажил хайх оролдлогод зориулсан зардал олгогдохгүй.

【Богино хугацааны сургалтад хамрагдах зардал】

Богино хугацааны сургалтад хамрагдах зардлыг Hello Work төвийн удирдамжийн дагуу ажилд орохын тулд 1 сар хүрэхгүй хугацааны мэргэжлийн дадлага сургалтад хамрагдаж төгссөн дараах (1) ~ (2)-н аль алинд харгалзах тэтгэмж авагчид олгоно.

(1) Мэргэжлийн дадлага сургалтад хамрагдахын өмнө Hello Work төвөөс уг сургалтад суух заавар авсан байх.

(2) Сургалтад суух заавар авсан өдрийн байдлаар хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагч байх

(3) Хүлээлтийн хугацаа дууссаны дараа сургалтад суусан байх.

(4) Мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж олгодог тогтолцоонд (Ерөнхий мэргэжлийн дадлага сургалт) хамрагддаг сургалтад суух бол мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж олгох болзлыг хангахгүй иргэн байх.

【Ажил хайх үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ ашиглах зардал】

Ажил хайх үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ ашиглах зардлыг ажил олгогчтой ярилцлагад орох гэх мэт, эсвэл мэргэжлийн дадлага сургалтад суухын тулд хүүхэд харах үйлчилгээ ашигласан тохиолдолд, дараах (1) ~ (2)-н аль алинд харгалзах тэтгэмж авагчид олгоно.

(1) Хүүхэд харах үйлчилгээ ашигласан өдрийн хувьд хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагч байх.

(2) Хүлээлтийн хугацаа дууссаны дараа хүүхэд харах үйлчилгээ ашигласан байх.

(3) “Ажил олгогчтой ярилцлагад орох гэх мэт” гэдэг нь ажил олгогчтой ярилцлагад орохоос гадна бичгийн шалгалт өгөх, Hello Work төв, эсвэл зөвшөөрөл, мэдэгдэл бүхий ажил зуучлах байгууллагаас (хөдөлмөрийн бирж) зохион байгуулдаг ажлын зөвлөгөө, ажилд зуучлуулах зэрэг орох ба мөн олон нийтийн захиргааны байгууллага зэргээс (хараат бус захиргааны байгууллага өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил хайгч иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллага, орон нутгийн засаг захиргаа, ажлын байрны талаар мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлдэг компани, сонины компани г.м) зохион байгуулдаг ажил хайх үйл ажиллагаатай холбоотой заавар, ганцаарчилсан зөвлөгөө өгөх боломжтой байгууллагын танилцуулга зэрэг багтана.

(4) “Мэргэжлийн дадлага сургалтад хамрагдах” гэдэг нь Hello Work төвийн заавар, зөвлөмжөөр нийтийн мэргэжлийн сургалт зэрэгт суух, хөдөлмөр эрхлэлт дэмжих төлөвлөгөөнд үндэслэн ажил хайгчийг дэмжих сургалтад суух, Hello Work төвийн заавраар төрөл бүрийн сургалтын байгууламжуудад элсэх, мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж олгогдох сургалт болон богино хугацааны сургалтад хамрагдах зардал олгогдох сургалтад суух түүнчлэн томилолт, шилжилтийг дэмжих ажил болгон хэрэгжүүлдэг захиалгат сургалт, курс зэрэгт хамрагдахыг хэлнэ.

(Өргөдөл гаргах талаар Hello Work төвийн ажилтнаас лавлаарай).

28 Ажилд орсны дараа дахин ажлаас гарсан бол яах вэ?

Шинээр тэтгэмж авах эрх авч чадаагүй тохиолдол


Тэтгэмжийн эхний хугацаанд (8-р хуудас) тэтгэмж олгох үлдэгдэл өдөр байгаа тохиолдолд, уг хоногийн хүрээнд үндсэн тэтгэмж авах боломжтой. Гэхдээ тэтгэмжид хамрагдах өдөр нь ажлаас гарсны дараа Hello Work төвд ирж мэдэгдэл гарган дахин ажилд орох өргөдөл гаргасан өдрөөс (тэтгэмжийн хязгаарлалт байгаа бол хязгаарлалтын хугацаа дууссаны дараа) тооцогдох тул, ажлаас гарсны дараа аль болох хурдан Hello Work төвд ирж мэдэгдэл гаргах хэрэгтэй. Хэрэв дахин ажилд орсон тэтгэмж зэрэг авсан бол уг тэтгэмж авсан өдрийн тоог хассан хэмжээгээр (бутархай хэсгийг хаяна) үндсэн тэтгэмж авах боломжтой.

Мэдэгдэл гаргахад шаардагдах зүйл

- Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ
- Ажлаас гарсан тухай хуудас эсвэл тэтгэмж авах эрхээ алдсанг тодорхойлох мэдэгдэл (дараа нь авчирч болно)

Жишээлбэл

Тэтгэмж тодорхойлсон өдөр 180 өдөр бол, үндсэн тэтгэмж 60 өдрийн тэтгэмж авсны дараа дахин ажилд орж, дахин ажилд орсон тэтгэмж 84 хоног авсны дараа ажлаас гарсан тохиолдол



$180 \text{ өдөр (тэтгэмж тодорхойлсон өдөр)} - 60 \text{ өдөр (үндсэн тэтгэмж олголт)} - 84 \text{ өдөр (дахин ажилд орсон тэтгэмж)} = 36 \text{ өдөр}$, энэ хэмжээний дотор үндсэн тэтгэмж авах боломжтой.

Дахин ажилд орсон тэтгэмж зэрэг авсны дараа дахин ажлаас гарсан бол тэтгэмж авах хугацаа сунгагдах онцгой тохиолдол байдаг.

Дахин ажилд орсон тэтгэмж зэрэг авсны дараа анх удаа ажлаас гарсан (шинээр тэтгэмж авах эрх үүссэний дараа ажлаас гарсныг тооцохгүй. Цаашид “дахин ажлаас гарах” гэнэ) өдөр нь тэтгэмж авах хугацааны дотор байхаас гадна дампуурал, ажлаас халагдсан гэх мэт шалтгаанаар дахин ажлаас гарсан иргэний хувьд тодорхой хугацаагаар тэтгэмж авах хугацаа сунгагдана.

Шинээр тэтгэмж авах эрх авсан тохиолдол

Ажилд орсон байгууллагатаа даатгуулагч болоод 12 сараас дээш (ажлаас халагдсан, дампуурсан зэрэг шалтгаанаар ажлаас гарсан бол 6 сараас дээш) ажилласны дараа ажлаас гарсан тохиолдолд ихэвчлэн шинээр хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авах эрх үүсэх тул уг тэтгэмж авах эрхээр үндсэн тэтгэмж авдаг. Энэ тохиолдолд тэтгэмж авах бүртгэлийг эхнээс нь хийх шаардлагатай болдог (2-р хуудас).

Улмаар шинээр тэтгэмж авах эрх авбал өмнөх тэтгэмж авах эрхэнд тулгуурлаж тэтгэмж авах боломжгүй.

29 Овог нэр болон гэрийн хаяг өөрчлөх бол

Овог нэр болон гэрийн хаяг өөрчлөх бол аль болох түргэн Hello Work төв зэрэгт мэдэгдэл гаргаарай. Гэрийн хаягаа сольсон бол хөдөлмөрийн даатгалын бүртгэл хийлгэх харьяаллын Hello Work төв зэрэг өөрчлөгдөх тохиолдол байдаг.

Мэдэгдэл гаргахад шаардагдах зүйлс

- ☐ Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ
- ☐ Овог нэр, гэрийн хаяг өөрчлөх мэдэгдэл (шаардлагатай мэдээлэл бичигдсэн оршин суугаа газрын тодорхойлолт г.м бичиг баримтыг хавсаргах)
- ☐ Төлбөр төлөгдөх санхүүгийн байгууллага өөрчлөх мэдэгдэл (овог нэр өөрчлөх тохиолдолд)

30 Хөдөлмөр эрхлэлт тогтвортой байдал хариуцсан газрын дарга • орон нутгийн тээврийн товчооны даргын заавраар нийтийн мэргэжлийн сургалт зэрэгт суух бол?

Hello Work төв нь таны дахин ажилд ороход тус болно гэж үзсэн тохиолдолд нийтийн мэргэжлийн сургалт зэрэгт хамрагдахыг зааварладаг.

Энэ тохиолдолд тэтгэмж тодорхойлсон өдрийн хэмжээгээр тэтгэмж олголт дууссаны дараа ч сургалт дуусах өдөр хүртэл үндсэн тэтгэмж сунгагдаж олгогддог.

Түүнээс гадна сургалтад шаардагдах зардлыг нөхөх зорилгоор сургалтын тэтгэмж, сургалтад ирж очих тэтгэмж зэрэг олгогдоно.

31 Өвчин болон бэртэл гэмтлийн улмаас ажиллаж чадахгүй болсон бол?

Тэтгэмж авах эрх тогтоосны дараа өвчин болон бэртэл гэмтлийн улмаас 15-с дээш өдөр ажиллаж чадахгүй байдалтай болсон бол үндсэн тэтгэмжийн оронд уг мөнгөн дүнтэй тэнцэх осол гэмтлийн тэтгэмж авах боломжтой. (Гэхдээ эрүүл мэндийн даатгал, үйлдвэрлэлийн ослын даатгал, бусад хуульд үндэслэн осол гэмтлийн тэтгэмжийн мөнгө, амралтын нөхөн олговрын тэтгэмж зэрэг авч байгаа бол, хүлээлтийн хугацаа болон тэтгэмжийн хязгаарлалтын хугацааны өдрүүдэд тэтгэмж авах боломжгүй).

Мөн үргэлжлүүлэн 30-с дээш өдөр ажиллах боломжгүй болсон тохиолдолд, осол гэмтлийн тэтгэмж авалгүйгээр тэтгэмж авах хугацааг сунгаж өвчин эдгэсний дараа үндсэн тэтгэмж авж ч болдог. (тэтгэмж авах хугацааг хугацааг сунгах тухай 17-р хуудас)

Осол гэмтлийн тэтгэмж хүсэх бүртгэлийн тухай

Осол гэмтлийн тэтгэмж хүсэхдээ дараах бичиг баримтыг Hello Work төв зэрэгт өгөөрэй. Өргөдөл гаргах хугацаа нь өвчин эдгэсний яг дараах магадлан тогтоох өдөр хүртэл байна.

1 Осол гэмтлийн тэтгэмж хүсэх өргөдөл

2 Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээ

※ Материалыг төлөөний хүн авчирж болох боловч, итгэмжлэл авчрах шаардлагатай.

Өвчин гэмтэл нь 1 сараас дээш хугацаа шаардах шинжтэй бол урьдчилан Hello Work төвтэй зөвлөлдөөрэй. Түүнчлэн эрүүл мэндийн даатгалын төрлийг шалгах тул “эрүүл мэндийн даатгалын карт” (хуулбар байсан ч болно) авчраарай.

32 Хэрэв тэтгэмж авагч нь тэтгэмж авч байх хугацаандаа нас барвал яах вэ?

Хэрэв тэтгэмж авч байх хугацаандаа тэтгэмж авагч нас барвал, уг иргэнтэй хамт амьдарч байсан ар гэрийнхэн нь нас барахын өмнөх өдөр (зарим тохиолдолд тухайн өдөр) хүртэлх үндсэн тэтгэмж зэрэг тэтгэмжийг авах эрхтэй. Үүнийг “Олгогдоогүй ажилгүйдлийн тэтгэмж” гэнэ.

Энэ тохиолдолд тэтгэмж авагч нас барсан өдрийн дараах өдрөөс 6 сарын дотор “олгогдоогүй ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдөл”-г Hello Work төв зэрэгт өгнө.

33 Ажилгүйдлийн тэтгэмжийг зөв авцгаая.

◎ Хууль бусаар тэтгэмж авах гэж юу вэ?

Ажилгүйдлийн тэтгэмж авах боломжгүй байтал, хуурамч эсвэл зохисгүй аргаар ажилгүйдлийн тэтгэмж авах эсвэл авахыг оролдохыг хэлнэ (**бодитойгоор тэтгэмж авсан эсэх хамаагүй**).

◎ Зөв мэдүүлээгүй бол хууль бусаар тэтгэмж авсан болно.

Жишээлбэл дараах тохиолдолд.

- Ажил хайх оролдлого хийгээгүй байж ажилгүйдэл тодорхойлох өргөдөлд хуурамч мэдэгдэл хийсэн.
- Ажилд орсон тохиолдолд (ажиллах хэлбэр нь хамаагүй. Туршилтын (дадлагын) хугацааг багтаана.) энэ тухай ажилгүйдэл тодорхойлох өргөдөлд мэдүүлээгүй, ажилд орсон өдөр, ажилд орж, ажилласан байдал болон орлогоо нуух гэх мэтээр худал мэдүүлсэн.
- Үйлдвэрлэлийн ослын даатгалын амралтын тэтгэмж (нөхөн олговор) болон эрүүл мэндийн даатгалын осол гэмтлийн тэтгэмж авч байгаагаа мэдүүлээгүй (хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авч дууссаны дараа, тэтгэмж авсан хугацаанд үйлдвэрлэлийн ослын даатгалын амралт нөхөн олговрын тэтгэмжийг ухраан тооцуулж авсан тохиолдол орно).
- Ажилд ороогүй байж орсон гэж худал мэдүүлсэн, ажилд орсон өдрийг худал мэдүүлж, дахин ажилд орсон иргэнд олгодог тэтгэмжийн өргөдөл гаргасан.
- Компанийн албан тушаалтанд томилогдсоноо мэдүүлээгүй.
- Худал мэдэгдэл хийсэн ажлаас гарсан тухай хуудас (ажлаас гарсан шалтгаан орно) өгсөн.

◎ Дүрмийг баримталж тэтгэмжээ зөв авцгаая.

Хэрэв хууль бусаар тэтгэмж авбал

- **Тэтгэмж олголт түдгэлзүүлэх** (тухайн өдрөөс хойш ажилгүйдлийн тэтгэмж зэрэг тэтгэмж авах эрхгүй болно)
- **Буцаан төлөх тушаал** (хууль бусаар авсан тэтгэмжийг бүрэн буцаан төлөх шаардлагатай болно)
- **Төлбөр төлөх тушаал** (хууль бусаар авсан тэтгэмжийг бүрэн буцаан төлөхөөс гадна, хууль бусаар авсан тэтгэмжийн мөнгөн дүнг **2 дахин нугалсан хэмжээний төлбөр төлөх шаардлагатай болно**)
- Хууль бусаар тэтгэмж авсан өдрийн дараах өдрөөс хугацаа хэтэрсэн төлбөр тооцогдоно.
- Эдгээр буцаан төлөлтийг төлөөгүй тохиолдолд **эд хөрөнгийг битүүмжилж** болзошгүй.
- **Хорлонтой үйлдэл гэж үзвэл луйврын хэргээр шийтгэл ногдуулах тохиолдол байдаг.**

34 Шийтгэлд гомдолтой байвал яах вэ?

Hello Work төвөөс шийдвэрлэсэн ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой шийтгэлд гомдолтой байвал уг шийтгэлийн тухай мэдсэн өдрийн маргаашаас 3 сарын дотор хөдөлмөрийн даатгалын байцаагчид шалгах хүсэлт гаргаж болно. Үүнийг “**шалгалт хийлгэх хүсэлт**” гэнэ.

Шалгалт хийлгэх хүсэлт гаргахдаа Hello Work төвөөр дамжуулж эсвэл шууд хөдөлмөрийн даатгалын байцаагчид хүсэлтээ мэдэгдэж болно.

Мөн хөдөлмөрийн даатгалын байцаагчийн гаргасан шийдвэрт гомдолтой байвал шийдвэрийн хуулбарыг илгээсэн өдрийн маргаашаас 2 сарын дотор хөдөлмөрийн даатгалын шалгалтын зөвлөлд **дахин шалгалт хийлгэх хүсэлт** гаргаж болно.

Хэрэв шалгалт хийлгэх хүсэлт гаргаснаас хойш 3 сар өнгөрсөн ч шалгалт хийлгэх хүсэлтийн талаар ямар нэгэн шийдвэр гараагүй бол шийдвэрийг хүлээлгүй хөдөлмөрийн даатгалын шалгалтын зөвлөлд хандаж дахин шалгалт хийлгэх хүсэлт гаргаж болно.

Hello Work төвөөс шийдвэрлэсэн ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой шийтгэлийг хүчингүй болгох нэхэмжлэлийг шалгалт хийлгэх хүсэлтийн шийдвэр гаргасны дараа, шийдвэр гарсныг мэдсэн өдрөөс 6 сарын дотор гаргаж болно (шийдвэр гарсан өдрөөс 1 жил өнгөрвөл тооцохгүй).

Хэрэв шалгалт хийлгэх хүсэлт гаргаснаас хойш 3 сар өнгөрсөн ч шалгалт хийлгэх хүсэлтийн талаар ямар нэгэн шийдвэр гараагүй бол шийдвэрийг хүлээлгүй хүчингүй болгох нэхэмжлэл гаргаж болно.

35 Мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмжийн тухай

1 Ерөнхий мэргэжлийн дадлага сургалттай холбогдох мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж

Ажилчдын бие даасан чадварыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах, дахин ажилд орох оролдлогыг дэмжихэд чиглэсэн хөдөлмөрийн даатгалын тэтгэмжийн тогтолцоо юм.

Тодорхой болзол хангасан хөдөлмөрийн даатгалын даатгуулагч (※1) (ажилтан) эсвэл даатгуулагч байсан иргэн (ажлаас гарсан) нь эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн дадлага сургалтад хамрагдаж төгссөн бол тухайн сургалтад хамрагдахад зарцуулсан сургалтын төлбөрийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийг (дээд хязгаартай) олгоно.

※1 Даатгуулагч гэдэг нь ерөнхий даатгуулагч болон өндөр настай даатгуулагчийг хэлнэ. Доорх зүйлд мөн адил хамаарна.

Тэтгэмж олгогдох иргэн

Ерөнхий мэргэжлийн дадлага сургалттай холбоотой сургалтын тэтгэмжийн төлбөр олгогдох иргэн нь дараах ①эсвэл ②-н аль нэгэнд хамаарч, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн дадлага сургалтад хамрагдаж төгссөн иргэн байна.

① Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч (хөдөлмөрийн даатгалын даатгуулагчаар ажиллаж байгаа хүн)

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн дадлага сургалтад хамрагдсан өдрөөс (цаашид “сургалт эхлэх өдөр” гэнэ.) тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа нь (※2) 3 ба түүнээс дээш жил байх (※3)

② Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч байсан иргэн (хөдөлмөрийн даатгалын даатгуулагч биш иргэн)

Сургалт эхлэх өдрөөс өмнө даатгуулагч байхаа больсон өдөр нь сургалт эхлэхийн өмнөх 1 жилийн дотор (холбогдох хугацааг сунгасан бол хамгийн уртдаа 20 хүртэл жил) (※4) байх, сургалт эхлэх өдөр тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа 3 ба түүнээс дээш жил байх (※3)

※2 Тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа гэдэг нь сургалт эхлэх өдөр хүртэл хугацаанд хөдөлмөрийн даатгалд хамрагддаг аж ахуй нэгжид даатгуулагчаар ажилласан хугацааг хэлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг Hello Work төвийн ажилтнаас лавлаарай.

※3 Ерөнхий мэргэжлийн дадлага сургалттай холбоотой сургалтын тэтгэмжийг анх удаа авах иргэний хувьд тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа 1 ба түүнээс дээш жил байх (түр арга хэмжээ)

※4 Сургалт эхлэх өдөр даатгуулагч биш иргэний дотор даатгуулагчийн эрхээ алдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд жирэмслэлт, төрөлт, хүүхэд асрах, өвчин, бэртэл гэмтэл зэрэг шалтгаанаар хамрагдах ёстой сургалтад үргэлжлүүлэн 30 өдөр ба түүнээс дээш хугацаагаар хамрагдаж чадахгүй тохиолдолд, Hello Work төвд уг шалтгааныг мэдэгдсэнээр даатгуулагчийн эрхээ алдсан өдрөөс сургалт эхлэх өдөр хүртэлх мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж олгогдох хугацаанд уг сургалтад хамрагдаж чадахгүй өдрүүдийг (хамгийн уртдаа 19 жил) нэмэн тооцож болдог.

Тэтгэмжийн хэмжээ

Холбогдох сургалтад хамрагдаж төгссөн бол тухайн сургалтад хамрагдахад зарцуулсан сургалтын зардлын 20% хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийг авах боломжтой.

Гэхдээ уг 20 хувьтай тэнцэх мөнгөний хэмжээ нь 100,000 иенээс давах бол олгогдох төлбөрийн хэмжээ нь 100,000 иен гэж үзвэл, 4000 иенээс хэтрэхгүй бол мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж авах боломжгүй болно.

※сургалт эхлэхээс 1 жилийн өмнө мэргэжлийн зөвлөхийн (мэргэжлийн чадварыг хөгжүүлэх тухай хуулийн 30-р зүйлийн 3-т заасан ажил мэргэжлийн зөвлөх) зохион байгуулдаг ажил мэргэжлийн талаар зөвлөгөө авсан бол уг зардлыг мэргэжлийн дадлага сургалтын зардалд нэмж болно. Гэхдээ уг зардлын хэмжээ нь 20,000 иенээс хэтрэвэл мэргэжлийн дадлага сургалтын зардалд хэрэглэж болох хэмжээ нь 20,000 иен хүртэл байна (зөвхөн хэйсэй 29-р оны 1 сарын 1 -ний өдрөөс хойш ажил мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө авсан бол).

2 Тодорхой ерөнхий мэргэжлийн дадлага сургалтад холбогдох мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж

Шуурхай дахин ажилд орох болон карьерын хөгжлийг эртнээс дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах, дахин ажилд орох оролдлогыг дэмжих зорилготой хөдөлмөрийн даатгалын тэтгэмжийн тогтолцоо юм.

Тодорхой болзол хангасан хөдөлмөрийн даатгалын даатгуулагч (※1) (ажилтан) эсвэл даатгуулагч байсан иргэн (ажлаас гарсан) нь эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн дадлага сургалтад хамрагдаж төгссөн бол тухайн сургалтад хамрагдахад зарцуулсан сургалтын төлбөрийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийг (дээд хязгаартай) олгоно.

※1 даатгуулагч гэдэг нь ерөнхий даатгуулагч болон өндөр настай даатгуулагчийг хэлнэ. Доорх зүйлд мөн адил хамаарна.

Тэтгэмж олгогдох иргэн

Тодорхой ерөнхий мэргэжлийн дадлага сургалттай холбоотой сургалтын тэтгэмжийн төлбөр олгогдох иргэн нь дараах ① эсвэл ②-н аль нэгэнд хамаарч, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн дадлага сургалтад хамрагдаж төгссөн иргэн байна.

① Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч (хөдөлмөрийн даатгалын даатгуулагчаар ажиллаж байгаа хүн)

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн дадлага сургалтад хамрагдсан өдрөөс (цаашид “сургалт эхлэх өдөр” гэнэ.) тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа нь (※2) 3 ба түүнээс дээш жил байх (※3)

② Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч байсан иргэн (хөдөлмөрийн даатгалын даатгуулагч биш иргэн)

Сургалт эхлэх өдрөөс өмнө даатгуулагч байхаа больсон өдөр нь сургалт эхлэхийн өмнөх 1 жилийн дотор (холбогдох хугацааг сунгасан бол хамгийн уртдаа 20 хүртэл жил) (※4) байх, сургалт эхлэх өдөр тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа 3 ба түүнээс дээш жил байх (※3)

※2 Тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа гэдэг нь сургалт эхлэх өдөр хүртэл хугацаанд хөдөлмөрийн даатгалд хамрагддаг аж ахуй нэгжид даатгуулагчаар ажилласан хугацааг хэлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг Hello Work төвийн ажилтнаас лавлаарай.

※3 Ерөнхий мэргэжлийн дадлага сургалттай холбоотой сургалтын тэтгэмжийг анх удаа авах иргэний хувьд тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа 1 ба түүнээс дээш жил байх (түр арга хэмжээ)

※4 Сургалт эхлэх өдөр даатгуулагч биш иргэний дотор даатгуулагчийн эрхээ алдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд жирэмслэлт, төрөлт, хүүхэд асрах, өвчин, бэртэл гэмтэл зэрэг шалтгаанаар хамрагдах ёстой сургалтад үргэлжлүүлэн 30 өдөр ба түүнээс дээш хугацаагаар хамрагдаж чадахгүй тохиолдолд, Hello Work төвд уг шалтгааныг мэдэгдсэнээр даатгуулагчийн эрхээ алдсан өдрөөс сургалт эхлэх өдөр хүртэлх мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж олгогдох хугацаанд уг сургалтад хамрагдаж чадахгүй өдрүүдийг (хамгийн уртдаа 19 жил) нэмэн тооцож болдог.

Тэтгэмжийн хэмжээ

Холбогдох сургалтад хамрагдаж төгссөн бол тухайн сургалтад хамрагдахад зарцуулсан сургалтын зардлын 40% хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийг авах боломжтой.

Гэхдээ уг 40 хувьтай тэнцэх мөнгөний хэмжээ нь 200,000 иенээс давах бол олгогдох төлбөрийн хэмжээ нь 200,000 иен гэж үзвэл, 4000 иенээс хэтрэхгүй бол мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж авах боломжгүй болно.

3 Мэргэшсэн практик сургалттай холбоотой мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж

Ажилчдын бие даасан, дунд урт хугацааны карьерын хөгжлийг дэмжих, ажил эрхлэлтийг тогтворжуулах, дахин ажил эрхлэлтийг дэмжих зорилготой хөдөлмөрийн даатгалын тэтгэмжийн тогтолцоо юм.

Тодорхой болзол хангасан хөдөлмөрийн даатгалын даатгуулагч (※1) (ажилтан) эсвэл даатгуулагч байсан иргэн (ажлаас гарсан) нь эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн дадлага сургалтад хамрагдаж төгссөн бол тухайн сургалтад хамрагдахад зарцуулсан сургалтын төлбөрийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийг (дээд хязгаартай) Hello Work төвөөс олгох тогтолцоо юм.

Түүнчлэн, тэтгэмж авч буй иргэн сургалтын үеэр ажилгүйдлийн байдалд байсан өдрүүдэд үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээтэй тэнцэх мөнгөн дүнгийн 80% (※2)-д тэнцэх мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж авч болох тохиолдол байдаг.

※1 Даатгуулагч гэдэг нь ерөнхий даатгуулагч болон өндөр настай даатгуулагчийг хэлнэ. Доорх зүйлд мөн адил хамаарна.

※2 2017 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө хамрагдсан мэргэшсэн практик сургалтын тэтгэмж төлөгдөх хэмжээ нь үндсэн тэтгэмжийн өдөр тутмын хэмжээтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгийн 50% байна.

Тэтгэмж олгогдох иргэн

Мэргэшсэн практик сургалттай холбоотой сургалтын тэтгэмжийн төлбөр олгогдох иргэн нь дараах ① эсвэл ②-н аль нэгэнд хамаарч, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн дадлага сургалтад хамрагдаж төгссөн иргэн байна.

① Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч

Мэргэшсэн практик сургалтад хамрагдаж эхэлсэн өдөр (цаашид “сургалт эхлэх өдөр” гэнэ.) хөдөлмөрийн даатгалын даатгуулагчийн дотор тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа (※3) нь 3 ба түүнээс дээш жил (※4) байх

② Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч байсан иргэний дотор даатгуулагчийн эрхээ алдсан өдрөөс хойш (ажлаас гарсан өдрийн дараах өдөр) сургалт эхлэх өдрийг хүртэлх хугацаа 1 жилийн дотор (холбогдох хугацааг сунгасан бол (※5) хамгийн уртдаа 20 хүртэл жил) байхаас гадна тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа 3 ба түүнээс дээш жил байх (※4) иргэн

※3 Тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа гэдэг нь сургалт эхлэх өдөр хүртэл хугацаанд хөдөлмөрийн даатгалд хамрагддаг аж ахуй нэгжид даатгуулагчаар ажилласан хугацааг хэлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг Hello Work төвийн ажилтнаас лавлаарай.

※4 Мэргэшсэн практик сургалттай холбоотой мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмжийг анх удаа авах иргэний хувьд тэтгэмжийн төлбөрийн болзлын хугацаа 2 ба түүнээс дээш жил байх (түр арга хэмжээ)

※5 Сургалт эхлэх өдөр даатгуулагч биш иргэний дотор, даатгуулагчийн эрхээ алдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд жирэмслэлт, төрөлт, хүүхэд асрах, өвчин, бэртэл гэмтэл зэрэг шалтгаанаар 30 өдрөөс дээш хугацаагаар хамрагдах ёстой сургалтад хамрагдаж чадахгүй тохиолдолд, Hello Work төвд уг шалтгааныг мэдэгдсэнээр даатгуулагчийн эрхээ алдсан өдрөөс сургалт эхлэх өдөр хүртэлх мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж олгогдох хугацаанд уг сургалтад хамрагдаж чадахгүй өдрүүдийг (хамгийн уртдаа 19 жил) нэмэн тооцож болдог.

Тэтгэмжийн хэмжээ

	Мэргэшсэн практик сургалтад хамрагдаж байх үед	Мэргэшсэн практик сургалт төгссөний дараа
Тэтгэмжийн хэмжээ (мэргэжлийн дадлага сургалтын зардал × баруун баганад байгаа хувь)	50% 4000 иенээс давах тохиолдолд. 1,200,000 иенээс давбал: 1,200,000 иен	Мэргэжил эзэмшиж төгссөн өдрийн дараах өдрөөс 1 жилийн дотор даатгуулагч болж ажилд орсон бол 70% 4000 иенээс давах тохиолдолд. 1,680,000 иенээс давбал: 1,680,000 иен Зүүн баганын төлөгдсөн дүнгийн зөрүүг нэмж олгоно.

※ Мэргэшсэн практик сургалтад хамрагдаж байх явцад олгогдох тэтгэмжийн мөнгөний дээд хэмжээ 1,200,000 иен нь

сургалтын хугацаа 3 жил байх үеийн дээд хэмжээ болно. Сургалтын хугацаа 1 жил бол 400,000 иен, 2 жил бол 800,000 иен дээд хэмжээ болно.

Түүнчлэн, мэргэшсэн практик сургалтад хамрагдаж төгссөний дараа олгогдох 1,680,000 иений тэтгэмж нь сургалтын хугацаа 3 жил байвал дээд хэмжээ болно. Хэрэв сургалтын хугацаа 1 жил бол хамгийн дээд хэмжээ нь 560,000 иен, 2 жил бол 1,120,000 иен болно.

※ Хэрэв 10 жилийн хугацаанд мэргэшсэн практик сургалтад олон удаа хамрагдсан бол анх удаа мэргэшсэн практик сургалтын мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж авсан сургалт эхэлсэн өдрийг (2017 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө сургалт эхлэх өдрийг оруулна.) эхлэл болгож 10 жилийн хугацаанд хамрагдсан мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмжийн мөнгөний нийт хэмжээ, 1,680,000 иен дээд хэмжээ болно.

Улмаар хуулийн хүрээнд хамгийн богинодоо 4 жилийн мэргэшсэн практик сургалтад хамрагдсан хүний хувьд 3 дахь жилийн сургалтын төгсгөлд 10 жилийн хугацаанд мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмжийн дээд хэмжээ 1,680,000 иен, 4 дэх жилийн сургалттай тэнцэх хэмжээ болгож хамгийн дээд хэмжээ 560,000 иен нэмэгдэнэ (4 жилийн хугацаанд 2,240,000 хүртэл).

※ 2017 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө хамрагдсан мэргэшсэн практик сургалтын тэтгэмж төлөгдөх хэмжээ нь мэргэжлийн дадлага сургалтын зардлын 40% (мэргэжил эзэмшиж төгссөний дараах өдрөөс 1 жилийн дотор даатгуулагчаар ажилд орсон бол 60%)-г эзэлнэ. Мөн тэтгэмжийн дээд хэмжээ нь жилд 320,000 иен (мэргэжил эзэмшиж төгссөний дараах өдрөөс 1 жилийн дотор даатгуулагчаар ажилд орсон бол 480,000 иен) байна.

4 Мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж олгогдох сургалт болон тэтгэмжийн болзлын талаар лавлах тухай

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн сургалтанд юу орох вэ

“Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн дадлага сургалтын жагсаалт” , Hello Work төвийн хүлээн авахаас харах боломжтой.

Мөн цахим хуудаснаас “Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон мэргэжлийн дадлага сургалт хайх систем” гэж харах боломжтой. (<https://www.kyufu.mhlw.go.jp/kensaku/>)

Мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж авах өргөдөл гаргахаасаа өмнө,

- ① Сургалт эхэлсэн (эхлэх төлөвлөгөөтэй байгаа) өдрийн байдлаар, та мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж авах болзлыг хангаж байгаа эсэх
- ② Суралцах хүсэлтэй мэргэжлийн дадлага сургалт нь эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тогтоосон сургалт эсэх

талаар “Мэргэжлийн дадлага сургалтын тэтгэмж олгох болзлын лавлах хуудас” -с, өөрийн харьяаллын Hello Work төвд хандаж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг Hello Work төвийн ажилтнаас лавлаарай.

36 Үргэлжлүүлэн ажилласны тэтгэмж

Хөдөлмөрийн даатгалын тэтгэмжид, ажиллаж байх явцад олгогддог “Үргэлжлүүлэн ажилласны тэтгэмж”-н тогтолцоо байдаг. Дахин ажилд орсны дараа хамрагдах боломжтой тул товч танилцуулъя. Тэтгэмжийн өргөдлийг ажилд орсон аж ахуй нэгжээрээ дамжуулж гаргана.

“Үргэлжлүүлэн ажилласны тэтгэмж”-д “Өндөр настны үргэлжлүүлэн ажилласны тэтгэмж”, “Хүүхэд асрах амралтын тэтгэмж” болон “Асаргааны амралтын тэтгэмж” багтана.

Өндөр настны үргэлжлүүлэн ажилласны тэтгэмжийн тухай

Өндөр настны үргэлжлүүлэн ажилласны тэтгэмж нь 65 нас хүртэлх иргэний үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн, тодорхой болзол хангасан 60-с дээш 65 хүртэл насны (далайчин бол төрсөн огноогоос шалтгаалж 55-с дээш 60 хүртэлх нас гэх тохиолдол байдаг. Тодорхой мэдээллийг ажилтнаас лавлах.) хөдөлмөрийн даатгалын даатгуулагчид (ажиллаж байгаа иргэн) олгогддог.

Өндөр настны үргэлжлүүлэн ажилласны тэтгэмжид, **өндөр настны үргэлжлүүлэн ажилласны үндсэн тэтгэмж, өндөр настны дахин ажилд орсны тэтгэмж** гэсэн 2 төрөл байдаг.

1 Өндөр настны үргэлжлүүлэн ажилласны үндсэн тэтгэмж

Хөдөлмөрийн даатгалын үндсэн тэтгэмж зэрэг (дахин ажилд орсон тэтгэмж гэх мэт үндсэн тэтгэмж олгогдсон гэж үзэх тэтгэмжүүд орно.) тэтгэмж аваагүй иргэнд олгогддог тэтгэмж юм.

Тэтгэмж олгох болзол

- 60 - 65 хүртэл насны даатгуулагч
- Даатгуулагч байсан хугацаа нь нийтдээ 5 жилээс дээш байх.
 - ※ “Даатгуулагч байсан хугацаа”-г тооцоолохдоо даатгуулсан хугацаанд цоорхой байвал, уг хугацаа нь 1 жилийн дотор бол өмнөх болон хойдох даатгалын хугацааг нэмж тооцно.
- Хэрэв үндсэн тэтгэмж эсвэл тусгай нэг удаагийн мөнгөн тэтгэмж авч байсан бол, түүний дараах хугацааг л тооцно.
- 60 наснаас хойш сар бүр төлсөн цалин хөлсний хэмжээ нь 60 нас хүрэхэд сарын цалингийн хэмжээний 75%-с доош буурсан байх
- 60 наснаас хойш сар бүр төлсөн цалин хөлсний хэмжээ нь тэтгэмжийн хязгаар (365,114 иен Жил бүрийн 8 сарын 1-д өөрчлөгдөж болзошгүй.)-с бага байх
- Хуанлийн сар бүрийн эхний өдрөөс сүүлчийн өдөр хүртэл даатгуулагчаар тасралтгүй ажилласан байх
- Хуанлийн сар бүр хүүхэд асрах амралтын тэтгэмж эсвэл асаргааны амралтын тэтгэмж авах боломжгүй байх

Олгогдох мөнгөний хэмжээ

Сар бүр төлсөн цалин хөлсний “бууралтын хувь” (%) (сар бүр төлсөн цалин хөлсний хэмжээ ÷ 60 нас хүрсэн үеийн сарын цалингийн хэмжээ × 100) -ний дагуу дараах томъёогоор тооцоолдог (гэхдээ тэтгэмжийн хязгаарыг харгалзан тэтгэмжийн олгогдох хэмжээ буурах, тэтгэмж олгогдохгүй байх тохиолдол байдаг).

- Бууралтын хувь 61%-с бага байх үед
Тэтгэмж олгогдох хэмжээ = Сар бүр төлсөн цалин хөлсний хэмжээ × 15%
- Бууралтын хувь 61%-с дээш 75%-с бага байх үед
Тэтгэмж олгогдох хэмжээ = Сар бүр төлсөн цалин хөлсний хэмжээ × 15% ~ 0% (бууралтын хувиас хамаарч тодорхой хувиар аажмаар буурна.)
- Бууралтын хувь 75%-с дээш байх үед
Тэтгэмж олгогдохгүй.
- ※ Тэтгэмж авч болох хугацаа нь 65 нас хүрэх сар хүртэл байна.

2 Өндөр настны дахин ажилд орсны тэтгэмж

Тэтгэмж авах эрхэд үндэслэн үндсэн тэтгэмж авсны дараа 60 нас хүрснээс хойш 1-с дээш жил үргэлжлүүлэн ажиллах нь тодорхой ажилд даатгуулагчаар ажилд орсон иргэнд олгогдох тэтгэмж юм. Үндсэн тэтгэмжийн тэтгэмж авах хугацааны дотор ажилд орж, ажилд орох өдрийн өмнөх өдөр үндсэн тэтгэмжийн тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо нь 100 өдрөөс дээш байх тохиолдолд олгогдоно.

Тэтгэмж олгох болзол

- 60 - 65 хүртэл насны даатгуулагч
- Даатгуулагч байсан хугацаа нь нийтдээ 5 жилээс дээш байх.
※“Даатгуулагч байсан хугацаа”-г тооцоолохдоо даатгуулсан хугацаанд цоорхой байвал, уг хугацаа нь 1 жилийн дотор бол өмнөх болон хойдох даатгалын хугацааг нэмж тооцно.
Хэрэв үндсэн тэтгэмж эсвэл тусгай нэг удаагийн мөнгөн тэтгэмж авч байсан бол, түүний дараах хугацааг л тооцно.
- Ажилд орсон өдрийн өмнөх өдөр үндсэн тэтгэмжийн тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо 100 өдрөөс дээш байх
- Дахин ажилд орсны дараах цалин хөлсний сарын хэмжээ нь үндсэн тэтгэмжийг тооцох үндэс болсон өдөр тутмын хөлсний хэмжээний 30 өдрийн хэмжээтэй тэнцэх хэмжээний 75%-с доош буурсан байх.
- Дахин ажилд орсны дараах сар бүр төлсөн цалин хөлсний хэмжээ нь тэтгэмжийн хязгаараас бага байх (365,114 иен Жил бүрийн 8 сарын 1-д өөрчлөгдөж болзошгүй.)
- Хуанлийн сар бүрийн эхний өдрөөс сүүлчийн өдөр хүртэл даатгуулагчаар тасралтгүй ажилласан байх
- Хуанлийн сар бүр хүүхэд асрах амралтын тэтгэмж эсвэл асаргааны амралтын тэтгэмж авах боломжгүй байх

Тэтгэмжийн хэмжээ

Ерөнхий ойлголт нь өндөр настны үргэлжлүүлэн ажилласны үндсэн тэтгэмжтэй ижил байна. Гэхдээ “бууралтын хувь” нь 60 нас хүрсэн үеийн цалин хөлс биш, дахин ажилд орсны дараах цалин хөлс нь үндсэн тэтгэмжийн жишиг болсон цалин хөлстэй харьцуулахад буурсан байгаа эсэхийг тооцоолно.

Түүнчлэн тэтгэмж авах боломжтой хугацаа нь үндсэн тэтгэмжийн тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тооноос хамаарч дараах байдалтай байна.

- Ажилд орох өдрийн өмнөх өдөр үндсэн тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо 200 өдрөөс дээш бол: Дахин ажилд орсны дараа 2 жил
- Ажилд орох өдрийн өмнөх өдөр үндсэн тэтгэмж олгох үлдэгдэл өдрийн тоо 100 өдрөөс дээш бол: Дахин ажилд орсны дараа 1 жил

※Энэ хугацаанд 65 нас хүрвэл, 65 нас хүрсэн сар хүртэл байна.

- ※ **Өндөр настны дахин ажилд орсны тэтгэмж болон дахин ажилд орсны тэтгэмжийг хамт авах боломжгүй.**
- ※ Үргэлжлүүлэн ажилласны тэтгэмжийн бодит хэмжээ нь “хөдөлмөрийн хөлсний хэмжээ” болон “тэтгэмжийн хязгаарын хэмжээ”-ний хамаарлаас шалтгаалан буурч эсвэл төлөгдөхгүй байх тохиолдол байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг Hello Work төвийн ажилтнаас лавлаарай.

Хүүхэд асрах амралтын тэтгэмжийн тухай

Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч (※) (эр эм хамаагүй) нь хүүхэд асрах амралт авсан тохиолдолд тодорхой болзлыг хангавал “хүүхэд асрах амралтын тэтгэмж” олгогдоно. Дэлгэрэнгүй мэдээллийг Hello Work төвийн ажилтнаас лавлаарай.

※Даатгуулагч гэдэг нь ерөнхий даатгуулагч болон өндөр настай даатгуулагчийг хэлнэ.

Асаргааны амралтын тэтгэмжийн тухай

Хөдөлмөрийн даатгалын даатгуулагч (※) нь гэр бүлээ асрахын тулд амралт авсан тохиолдолд тодорхой болзлыг хангавал “асаргааны амралтын тэтгэмж” олгогдоно. Дэлгэрэнгүй мэдээллийг Hello Work төвийн ажилтнаас лавлаарай.

※Даатгуулагч гэдэг нь ерөнхий даатгуулагч болон өндөр настай даатгуулагчийг хэлнэ.

37 Хөдөлмөрийн даатгал, өндөр настны халамжийн тэтгэврийн зохицуулалтын тухай

Ажил хайгчийн тэтгэмж (үндсэн тэтгэмж) ба өндөр настны халамжийн тэтгэвэр, хамтран туслалцах нийгэмлэгийн тэтгэвэрт төлбөрийн хавсарсан зохицуулалт хийгдэнэ. Тэтгэмж авах эрх үүсэх өндөр настны халамжийн тэтгэвэр авах эрхтэй иргэн нь ажил хайгчийн тэтгэмж (үндсэн тэтгэмж) авах хугацаанд өндөр настны халамжийн тэтгэвэр, хамтран туслалцах нийгэмлэгийн тэтгэврийн олголт зогсоно.

Энэ нь ажил хайгчийн тэтгэмж олгох агуулга өөрчлөгдөхгүй, тэтгэврийн олголт л зогсоно гэсэн үг юм. Ажил хайгчийн тэтгэмжээс гадна өндөр настны үргэлжлүүлэн ажилласан тэтгэмж ч төлбөрийн зохицуулалтад хамрагдана.

Хавсарсан зохицуулалтын талаар дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэл хийсэн эсвэл хийлгэх гэж байгаа тэтгэврийн албанаас лавлаарай.

38 Үндэсний эрүүл мэндийн даатгал (татвар) -н хөнгөлөлтийн тухай

Дампуурал болон ажлаас халагдсан зэрэг шалтгааны улмаас ажлаасаа гарсан иргэн (тусгай эрхтэй тэтгэмж авагч), ажлаас түдгэлзүүлсэн зэрэг шалтгаанаар ажилгүй болсон иргэний (тусгай шалтгаантай ажилгүй болсон этгээд) үндэсний эрүүл мэндийн даатгал (татвар) буурна.

Хамрагдах иргэн

Ажлаас гарсан өдрийн дараах өдрөөс дараа жилийн эцэс хүртэлх хугацаанд

- 1 Хөдөлмөрийн даатгалын тусгай эрхтэй тэтгэмж авагч (жишээлбэл: дампуурал, ажлаас халагдсан зэрэг шалтгаанаар ажилгүй болсон)
- 2 Хөдөлмөрийн даатгалын тусгай шалтгаантай тэтгэмж авагч (жишээлбэл: ажлаас түдгэлзүүлсэн зэрэг шалтгаанаар ажилгүй болсон)

гэдэг заалтаар ажил хайгчийн тэтгэмж (үндсэн тэтгэмж г.м) авдаг иргэн байна.

※Хөдөлмөрийн даатгалын тэтгэмж авагчийн гэрчилгээний ажлаас гарсан шалтгаан нь

11,12,21,22,31,32,23,33,34-д хамаарах иргэн

※Өндөр настны тэтгэмж авагч болон тусгай даатгуулагчийн тэтгэмж авагч хамрагдахгүй.

Бууралтын хэмжээ

Үндэсний эрүүл мэндийн даатгал (татвар) нь өмнөх жилийн орлогоос хамаарч тооцогдоно.

Бууралтын хэмжээ нь өмнөх жилийн цалингийн орлогын 30/100 гэж тооцож бууруулна.

※Тодорхой бууралтын хэмжээний талаар хотын захиргаанаас лавлаарай.

Бууралтын хугацаа

Ажлаас гарсан өдрийн дараах өдрөөс дараа жилийн эцэс хүртэлх хугацаа.

※Хөдөлмөрийн даатгалын ажил хайгчийн тэтгэмж (үндсэн тэтгэмж г.м) авах хугацаанаас ялгаатай.

※Мэдэгдэл гаргах нь оройтсон ч ухраан тооцож бууралт эдлэх боломжтой.

※Үндэсний эрүүл мэндийн даатгалд хамрагдаж байх явцдаа ажилд орсон ч үргэлжлүүлэн хамрагдах боломжтой боловч компанийн эрүүл мэндийн даатгалд хамрагдах зэргээр үндэсний эрүүл мэндийн даатгалаас гарвал дуусгавар болно.

Хөнгөлөлт авахад мэдэгдэл гаргах шаардлагатай. Тогтолцооны тухай дэлгэрэнгүй тайлбарыг оршин суугаа хотынхоо үндэсний эрүүл мэндийн даатгалын газраас лавлана уу.

Гол бүртгэлийн жагсаалт

Бүртгэл шаардлагатай болох тохиолдлууд	Бүртгэлийн эцсийн хугацаа	Шаардагдах бичиг	Хавсаргах бичиг, Гэрчлэгч	Холбогдох хуудас
Өвчин, Бэртэлт, Жирэмслэлт, Төрөлт, Хүүхэд өсгөх, Хамаатан садны асаргаа зэрэг шалтгаанаар тэтгэмж авах хугацааг сунгах үед	Ажилд явах боломжгүй болоод 30 хоногсон өдрийн маргаашаас хойш, эртхэн бүртгүүлэх журамтай боловч сунгалт хийсний дараа тэтгэмж авах хугацааны сүүлийн өдөр хүртэлх хугацааны дотор байвал бүртгүүлэх боломжтой	Тэтгэмжид авах хугацааг сунгах өргөдөл, тэтгэмж авагчийн гэрчилгээ	Эх үрийн дэвтэр, эмнэлгийн акт г.м	17-р хуудас
Ажилд орсон эсвэл бизнес эхлүүлэх нь тодорхой болсон үед	Зарчмын хувьд, ажилд орох өдрийн өмнөх өдөр	Ажлын газрын тодорхойлолт (ажилд авах огноо бичигдсэн), тэтгэмж авагчийн гэрчилгээ	Ажил олгогч	20-р хуудас
Түргэн хугацаанд дахин ажилд орсон үед	Ажилд орсон өдрийн маргаашаас 1 сарын дотор	Дахин ажилд орсон тэтгэмж олгох өргөдөл, тэтгэмж авагчийн гэрчилгээ	Ажил олгогч	20-р хуудас
Хөгжлийн бэрхшээлтэй зэрэг иргэн Hello Work төвөөр дамжуулж ажилд орсон үед	Ажилд орсон өдрийн маргаашаас 1 сарын дотор	Байнгын ажилд орох бэлтгэлийн тэтгэмж олгох өргөдөл, тэтгэмж авагчийн гэрчилгээ	Ажил олгогч	25-р хуудас
Овог нэр болон гэрийн хаяг зэрэг өөрчлөгдсөн үед	Дараагийн магадлан тогтоох өдөр хүртэл (өөр Hello Work төвийн хариуцдаг бүс рүү шилжих бол урьдчилан мэдэгдэх)	Тэтгэмж авагчийн овог нэр, гэрийн хаяг өөрчлөх мэдэгдэл, тэтгэмж авагчийн гэрчилгээ	Оршин суугчийн тодорхойлолт г.м	30-р хуудас
Өвчин, бэртэл гэмтлээс болж үргэлжлүүлэн 15-аас дээш хоног ажиллаж чадахгүй болсон үед	Эдгэрсний дараах магадлан тогтоох өдөр хүртэл (эдгэхэд хугацаа шаардах бол, Hello Work төвтэй зөвлөх)	Бэртэл гэмтлийн тэтгэмж олгох өргөдөл, тэтгэмж авагчийн гэрчилгээ	Хариуцсан эмч	30-р хуудас
Нас барсан тэтгэмж авагчийн оронд ар гэрийнхэн нь ажилгүйдлийн тэтгэмж авах үед	Нас барсан өдрийн маргаашаас 6 сарын дотор	Олгогдоогүй ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдөл, тэтгэмж авагчийн гэрчилгээ	Нас барсан тухай магадлагаа, өрхийн бүх гишүүн багтсан оршин суугчийн тодорхойлолт, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн бүрэн хуулбар г.м	31-р хуудас

面 接 証 明 書

住 所

氏 名

上記の者について、以下のとおり、当社の採用試験（面接）を行いました。

採用試験（面接） 実 施 日 時	年	月	日	時	分	から
	年	月	日	時	分	まで

上記のとおり相違ないことを証明します。

年 月 日

公共職業安定所長 殿

所在地

名 称

事業所

代表者名

印

電話番号

採用証明書

別紙 1

本人記入欄

支給番号		
フリガナ 氏 名	生年月日	年 月 日
(〒)		
住所		(電話 ())

この採用証明書は、正しい雇用年月日を把握し、適正な給付を行うため、事業主の皆様
様に証明していただくものです。必ず出勤簿、タイムカード、労働者名簿等の関係書類
を確認の上、証明してください。

万一、雇用年月日を事実と相違して記載し、それが不正受給につながる場合は、雇用
保険法第 10 条の 4 第 2 項により失業等給付を受けた者と連帯して返還及び納付してい
ただく場合があります。

事業主記入欄

雇用（予定）年月日 （試用期間を含む。）	年 月 日	雇用の内定日	年 月 日
雇用（予定）年月日以前に臨時、アルバイ ト、日雇い等で働いた期間の有無（該当す る箇所を○で囲んでください。） ※裏面「雇用年月日」についての注意事 項」を必ずご参照ください。	ア 無し イ 有り（具体的な就労期間を記入し てください。） 年 月 日 ～ 年 月 日 (日間)		
職 種			
今回採用された方の採用経路について、以下の項目の該当する箇所を○で囲んでく ださい。 ア 安定所の紹介（関連機関含む） ウ 求人広告、新聞折り込み等 イ 職業紹介事業者の紹介 エ 知人、取引先等の紹介			
上記のとおり相違ないことを証明します。 公共職業安定所長 殿 年 月 日 事業所 所在地 名 称 代表者名 電 話 適用事業所番号			
印			

ハローワークでは、各種技能を持たれた方々が多数仕事を探されています。

- 1 今後の採用予定
☐ ある ☐ ない
- 2 現在、ハローワークに求人を
出していただいていますか？
☐ 出している ☐ 出していない

職種	採用予定人数	採用の時期
		月頃
		月頃

「雇用年月日」についての注意事項


- ① まず、社員や従業員として、いつから在籍されているかを確認してください。「雇用年月日」は、本人との間で取り決めをされた

「在籍となる初日」のことをいいます。

通常は、「最初に出勤される予定の日」や「実際に出勤された日」となりますが、「在籍となる初日」と最初に出勤される日が異なる場合があるので、ご注意ください。

(例1) 雇用年月日が休祝日に当たる場合

●日は会社休業日




(例2) 出勤すべき初日に欠勤された場合



- ② 「在籍となる初日」には、正社員や本採用に限らず、臨時やパート、見習い、試用、研修等で在籍している期間も含みます。

(例3) 正社員に切替前に、臨時・パート・試用期間・アルバイト等がある場合



		-							-	
--	--	---	--	--	--	--	--	--	---	--

氏 名

生年月日 年 月 日生

傷病等の状態 及びその程度	
傷病等のため職 業に就くことができ なかったと認めら れる期間	年 月 日 から 年 月 日 まで 日間

上記のとおり証明します。

年 月 日

公共職業安定所長 殿

所在地

医師又は

診療担当者名

印

離 職 状 況 証 明 書

(雇用保険未加入者用)

申請者が記入	フリガナ		生年月日	昭和			
	氏 名			年	月	日	
	住 所	〒 ー					
TEL () ー							

事業主が記入してください。	雇用年月日	令和 年 月 日	離職年月日	令和 年 月 日
	離職理由 …… 該当するものを○で囲み、具体的な事情を記載してください。			
	イ 解雇 ロ 倒産による退職 ハ 契約期間満了	具体的な事情		
	ニ 事業主の勧奨による退職 ホ 定年(歳)			
	ヘ 定年(歳)後の勤務延長又は再雇用の終了(歳)			
ト その他				
上記のとおり相違ないことを証明します。 令和 年 月 日 公共職業安定所長 殿 事業所の所在地及び名称 事業主氏名 ⑩				

※ 事業主の方へお願い

- 1 この証明は、貴事業所で雇入れた方のうち、雇用保険被保険者として資格取得をされなかった方についてご記入ください。
- 2 雇入年月日・離職年月日については、試用期間・研修期間等があった場合には、その期間を含めてご記入ください。
- 3 雇用保険に加入いただいている場合は、離職票Ⅰ・Ⅱをご使用ください。

【安定所記載欄】

令和2年（2020年）

曜日型		日 月 火 水 木 金 土							曜日型		日 月 火 水 木 金 土							曜日型		日 月 火 水 木 金 土						
週型									週型									週型								
1	4				1	2	3	4	5	1						1	2	9	3			1	2	3	4	5
	1	5	6	7	8	9	10	11		2	3	4	5	6	7	8	9		4	6	7	8	9	10	11	12
	2	12	13	14	15	16	17	18		3	10	11	12	13	14	15	16		1	13	14	15	16	17	18	19
	3	19	20	21	22	23	24	25		4	17	18	19	20	21	22	23		2	20	21	22	23	24	25	26
	4	26	27	28	29	30	31			1	24	25	26	27	28	29	30		3	27	28	29	30			
2	4							1	6	2		1	2	3	4	5	6	10	3					1	2	3
	1	2	3	4	5	6	7	8		3	7	8	9	10	11	12	13		4	4	5	6	7	8	9	10
	2	9	10	11	12	13	14	15		4	14	15	16	17	18	19	20		1	11	12	13	14	15	16	17
	3	16	17	18	19	20	21	22		1	21	22	23	24	25	26	27		2	18	19	20	21	22	23	24
	4	23	24	25	26	27	28	29			2	28	29	30					3	25	26	27	28	29	30	31
3	1	1	2	3	4	5	6	7	7	2				1	2	3	4	11	4	1	2	3	4	5	6	7
	2	8	9	10	11	12	13	14		3	5	6	7	8	9	10	11		1	8	9	10	11	12	13	14
	3	15	16	17	18	19	20	21		4	12	13	14	15	16	17	18		2	15	16	17	18	19	20	21
	4	22	23	24	25	26	27	28		1	19	20	21	22	23	24	25		3	22	23	24	25	26	27	28
	1	29	30	31						2	26	27	28	29	30	31			4	29	30					
4	1				1	2	3	4	8	2						1		12	4			1	2	3	4	5
	2	5	6	7	8	9	10	11		3	2	3	4	5	6	7	8		1	6	7	8	9	10	11	12
	3	12	13	14	15	16	17	18		4	9	10	11	12	13	14	15		2	13	14	15	16	17	18	19
	4	19	20	21	22	23	24	25		1	16	17	18	19	20	21	22		3	20	21	22	23	24	25	26
	1	26	27	28	29	30				2	23	24	25	26	27	28	29		4	27	28	29	30	31		
										3	30	31														

※ 春分の日、秋分の日は未定

令和3年（2021年）

曜日型		日 月 火 水 木 金 土							曜日型		日 月 火 水 木 金 土							曜日型		日 月 火 水 木 金 土											
週型									週型									週型													
1	4	1 2							5	1	1							9	3	1 2 3 4											
	1	3	4	5	6	7	8	9		2	2	3	4	5	6	7	8		4	5	6	7	8	9	10	11					
	2	10	11	12	13	14	15	16		3	9	10	11	12	13	14	15		1	12	13	14	15	16	17	18					
	3	17	18	19	20	21	22	23		4	16	17	18	19	20	21	22		2	19	20	21	22	23	24	25					
	4	24	25	26	27	28	29	30		1	23	24	25	26	27	28	29		3	26	27	28	29	30							
1	31								2	30	31																				
2	1	1 2 3 4 5 6							6	2	1 2 3 4 5							10	3	1 2											
	2	7	8	9	10	11	12	13		3	6	7	8	9	10	11	12		4	3	4	5	6	7	8	9					
	3	14	15	16	17	18	19	20		4	13	14	15	16	17	18	19		1	10	11	12	13	14	15	16					
	4	21	22	23	24	25	26	27		1	20	21	22	23	24	25	26		2	17	18	19	20	21	22	23					
	1	28								2	27	28	29	30								3	24	25	26	27	28	29	30		
																		4	31												
3	1	1 2 3 4 5 6							7	2	1 2 3							11	4	1 2 3 4 5 6											
	2	7	8	9	10	11	12	13		3	4	5	6	7	8	9	10		1	7	8	9	10	11	12	13					
	3	14	15	16	17	18	19	20		4	11	12	13	14	15	16	17		2	14	15	16	17	18	19	20					
	4	21	22	23	24	25	26	27		1	18	19	20	21	22	23	24		3	21	22	23	24	25	26	27					
	1	28	29	30	31								2	25	26	27	28		29	30	31	4	28	29	30						
4	1	1 2 3							8	3	1 2 3 4 5 6 7							12	4	1 2 3 4											
	2	4	5	6	7	8	9	10		4	8	9	10	11	12	13	14		1	5	6	7	8	9	10	11					
	3	11	12	13	14	15	16	17		1	15	16	17	18	19	20	21		2	12	13	14	15	16	17	18					
	4	18	19	20	21	22	23	24		2	22	23	24	25	26	27	28		3	19	20	21	22	23	24	25					
	1	25	26	27	28	29	30								3	29	30		31								4	26	27	28	29

※ 春分の日、秋分の日は未定

Зөвлөгөө өгөх газруудын жагсаалт

Гэрийнхээ ойролцоох Hello work-г эндээс хайх боломжтой.

<https://www.mhlw.go.jp/content/000637894.pdf>



Орчуулагчтай Hello Work бол мэдээллийг эндээс авна уу

<https://www.mhlw.go.jp/content/000592865.pdf>



Хөдөлмөрийн нөхцлийн талаар зөвлөгөө авахыг хүсвэл мэдээллийг эндээс авна уу

https://www.check-roudou.mhlw.go.jp/soudan/foreigner_eng.html

